

ЦАГ





сэтгүүл
ТӨР

ХУМЧИУС



**ДӨРВӨН
ЗАЯА**

2021 ОНЫ МОНГОЛЫН ЗУРАГЛАЛ



Нээлттэй Нийгэм Форум нь 2004 оны зургадугаар сард Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн [Соросын сан]-г өөрчлөн байгуулсны үндсэн дээр бий болсон Монголын төрийн бус байгууллага юм.

Нээлттэй Нийгэм Форумын үндсэн зорилго нь чанартай мэдээлэл, судалгаа, олон талт хэлэлцүүлэгт тулгуурлан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэдийн идэвхтэй оролцоог дэмжихэд оршино.

Нээлттэй Нийгэм Форум иргэний нийгмийн бусад байгууллагатай нягт тншилэн ажиллахын сацуу парламент, засгийн газартай өргөн хүрээнд хамтран ажилладаг. Мөн улс оронд өрнөж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн цйл явцын талаар донор болон олон улсын байгууллагуудтай байнга зөвлөлддөг болно.

2021: МОНГОЛЫН ЗУРАГЛАЛ

Сценари буюу зураглал нь тохиож болох ирээдүйн тухай өгүүлэмж юм. Бид ирээдүйг урьдчилан хэлж чадахгүй ч ирээдүйн талаар сайтар тунгаан бодож чадна. Сценари нь энэхүү ирээдүйн талаарх биеллээ олж болохуйц, санаа сэдэл өдөөхүйц, утга авцалдаатай төсөөлөл боловсруулах, улмаар түүний үр дагаврыг авч үзэх арга юм. Бидний ирээдүй ямар ч байж болох бөгөөд бид, бидний үр хүүхэд бидний хүлээж байснаас тэс өөр ертөнцөд амьдарч мэдэх юм гэдгийг сценариуд харуулдаг.

Сүүлийн жилүүдэд бид нэг зүйлийг тодорхой мэдэх болсон. Энэ бол Монгол Улс асар их эрдэс баялагтай... Гэхдээ хариултыг нь хэлж мэдэхгүй олон асуулт байна. Баялаг маань хэр эрэлт хэрэгцээтэй байх, үнэ нь хэрхэх, баялгийнхаа ашиг тусыг нийтээрээ хүртэж чадах уу, эсвэл нийгмийн цөөн хэсгийн олз болоод өнгөрөх үү, олсон орлогоо бид үрэн таран хийчих үү, эсвэл ухаалгаар зарцуулж хөгжил дэвшилд хүрэх үү гэх мэт.

Иймээс бид бүхний цаашид хийх аливаа сонголтоос хамааран биднийг ямар ирээдүй хүлээж байж болох талаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор эдгээр сценарийг боловсрууллаа.

2003-2004 онд Нээлттэй Нийгэм Форум “Эдийн засгийн хөгжлийн ирээдүйн дүр зураг” боловсруулж тухайн үед улс орон маань эдийн засгийн ямар ямар сорилттой тулгарч буй талаар олон нийтэд танилцуулж байв. Бид дээрх туршилтаа үндэслэн энэ удаа уул уурхайгаас орох орлогоо хэрхэн зарцуулахаас хамааруулан “2021 оны Монголын зураглал” сценариуд боловсруулахаар шийдсэн юм. Энэхүү үйл ажиллагаа сонирхогч талуудын өргөн оролцоонд тулгуурласан бөгөөд хувийн болон төр, иргэний нийгмийн салбарын 30 орчим төлөөлөл гурван ч удаа 1-2 өдрөөр уулзалт зохион байгуулж, баг болон ажиллаж эдгээр сценарийг боловсрууллаа. Мөн стратеги төлөвлөх, сценари боловсруулах чиглэлээр зөвлөгөө өгдөг “Скилфул мийнз” инк., орлогын ил тод байдлын асуудлаар олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Орлогын Ажиглалт Хүрээлэн” зэрэг байгууллагын зөвлөхүүд үнэтэй дэмжлэг үзүүлсэн юм.

Үүл уурхайн сэдвээр хэвлэгдсэн ном, тайлангуудтай танилцахыг хүсвэл www.forum.mn болон Нээлттэй Нийгэм Форумын хөгжлийн мэдээллийн төвд хандана уу.

Сценари боловсруулахад “хөдөлгөгч хүчин” буюу шийдвэрлэх нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох нь нэн чухал. Манай орны хувьд эрдэс баялгаа зохистой ашиглаж, түүнээс олох орлогыг зөв зарцуулах явдал улс орны цаашдын хөгжилд тэргүүлэх нөлөөтэй гэж сценари боловсруулагчид үзсэний дагуу баялгаасаа орлого авч чадах эсэх, чадсан нөхцөлд хэрхэн зарцуулахаас хамаарч дөрвөн өөр ирээдүйн дүр зураг гарсан юм.



Эдгээр сценарийг боловсруулахдаа бид өөрсдөөс хамаарах дотоод хүчин зүйлсэд илүү анхаарал хандуулж, харин гадаад хүчин зүйлсийг харьцангуй тогтвортой, дөрвөн сценарийн хувьд ижил байхаар төсөөлсөн юм. Тухайлбал, ашигт малтмалын үнэ ерөнхийдөө тогтвортой өндөр байх ч 2018 – 2019 онд огцом буурах нөхцөлд тулгуурлалаа.

Сценари боловсруулагчид дөрвөн багт хуваагдаж эдгээр сценарийг нарийвчлан бичсэн нь ийнхүү уншигч оны хүртээл болж байна. Эдгээр сценари нь Заяа гэх залуу бүсгүй, түүний гэр бүл, найз нөхдийн амьдралын дөрвөн өөр түүх бөгөөд улс орон баялгаа хэрхэн ашиглахаас хамаарч жирийн монгол хүн дөрвөн өөр сценарид хэрхэн амьдрах тухай өгүүлж байгаа юм.

Сценариудыг уншихдаа прогноз биш гэдгийг санах нь чухал. Сценари бичигчид ирээдүй яг ийм, тэр ч байтугай иймэрхүү байна гэж хэлж байгаа юм биш. Иймээс эрхэм уншигч Та эдгээр сценарийг дотоод зөрчилгүй, үнэмшилтэй, эргэцүүлэл төрүүлэхүйц болж чадсан эсэхийг нь цэгцэж уншаарай.



ДӨРВӨН ЗАЯА

ЗОРГООР НЬ ОРХИСОН БОЛ ИЛҮҮ БАЙХ ХУВЬ ЗАЯА

...Баян болно гэж Заяа хэзээ ч бодож байсангүй. Харин хэзээ нэгэн цагт дундаж ангийн хэмжээнд сайхан амьдарна гэж бодож байсан үе Заяад бий...



ӨГӨӨМӨРТ НАЙДСАН МОНГОЛ ЗАЯА

...Заяа өөрийн болон хүүхдүүдийн сар бүр авдаг тэтгэмж, нөхрийн цалин зэргийгээ нийлүүлээд өдөр тутмын амьдралаа залуулж, тун удахгүй нөгөө амласан сайхан амьдрал ирнэ гэж найдаад явж байлаа...



ӨМНӨГОВИЙН “НОГООН КАРТ”-НЫ ЭЗЭН ЗАЯА

...Өвөр Монгол-Өмнөговийн эрчим хүчний цогцолборын Баруун Цанхи нүүрсний уурхайн мастер Заяа “Оюу Толгой” цэнгэлдэх хүрээлэнд улсын наадам үзэх эрхээр шагнуулжээ...

ИХ ХУВЬ ЗАЯАТАЙ ОРНЫ ИРГЭН ЗАЯА

...Заяа баахан сайд, захирлуудын араас үг хэлэхдээ, Дорнод нутгийн газрын тос улс орныг тэтгэж байгаа нь сайн хэрэг, гэхдээ байгаль орчин, малын бэлчээрт үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах хэрэгтэйг сануулаад авсан түүхтэй...



Тайлбар: Энэхүү сценариудын өгүүлэмжид тахируулан бодит зургууд сонгож оруулсан болно.

Нээлттэй Нийгэм Форум
 Жамъян гүней гудамж -5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
 Утас: 976-11-313207
 Факс: 976-11-324857
 www.forum.mn

Хатагч зургийг Б.Баясгалан, 2012.

ЗОРГООР НЬ ОРХИСОН БОЛ ИЛҮҮ БАЙХ ХУВЬ ЗАЯА

Баян болно гэж Заяа хэзээ ч бодож байсангүй. Харин хэзээ нэгэн цагт дундаж ангийн хэмжээнд сайхан амьдарна гэж бодож байсан үе түүнд бий.

1

Өнөөдөр 2021 оны 12-р сарын 31. Хорвоод мэндтгээд 37 нас хүрч буй Заяа бүсгүй өнөө орой Шинэ жилийн баяраа тэмдэглэхээр бэлтгэж суугаа ч түүнд баяр хөөрийн сэтгэл очүүхэн ч үгүй. Заяагийнх амьдралаа төвхнүүлж чадаагүй, өдөр хоногийг чадан ядан өнгөрөөж буй 800 гаруй мянган гэр бүлийн нэг. 10 жилийн өмнө яригдаж, олон хүнд итгэлийн оч бадрааж асан уул уурхайн төслүүд сураг тасарч, баялгаа гадныханд зарж хөлжигчид, ил далд аргаар орд газруудыг гартаа оруулсан уурхайн эзэд Монголоос хол газарт аж төрөхүйд дундаж жирийн айл өрхүүд ийнхүү толгой дараалан сөхөрч эхэлсний бодит жиншээ болж буйдаа гутрах Заяа маргаашний тухай бодохоос аль болох зайлсхийнэ.

Тэрбээр одоогоос яг хорин жилийн өмнө дээд сургуульд элсэх шалгалтад тэр үеийн Архангай аймгаас тэнцэн Улаанбаатарт ирж эрх зүйчийн мэргэжил эзэмшин, гэр бүл зохиож хоёр хүүхдийн эх болжээ. Гэр бүлийн түшиг тулгуур болох хань Орхон нь эзэд нь тодорхойгүй нэгэн жижиг компанид хамгаалагчийн ажил хийсээр өдийг хүрчээ. Тэрбээр олон жижиг шороон ордоос олборлолт хийдэг компанийн өмч хөрөнгийг хулгайгаас хамгаалах үүрэгтэй хамгаалагч гэж нэрийдсэн олон ажилчны нэг юм.

Хүүхдүүд нь 13, долоон настай агаад дунд сургуульд суралцдаг. Монгол Улсын боловсролын систем өдгөө тун эмзэг болжээ. Мөнгөтэй айлын хүүхдүүд хувийн сургуульд болон төлбөр авдаг улсын сургуульд сурна. Харин Заяагийнх шиг айлын хүүхдүүд жирийн улсын сургуульд явдаг. Ийм сургуулийн багш нарын цалин муу тул багш барагтай бол тогтохгүй, дээрээс нь анги танхим хүрэлцэхгүйгээс хүүхдүүд нэг ангид олноороо хий үймэлдэж цагийг барах нь хэвийн үзэгдэл болжээ.

Аргын тооллын шинэ он хот газрынхны хувьд эрхэм баяр болдог ч Заяагийн хувьд сүүлийн тав, зургаан удаагийн шинэ жил айдас, битүүхэн гунигийг дагуулах болов. Хүүхдүүд нь эрүүл саруул өсөж бойжиж байгаа ч цаашид хүний дайтай амьдрах баталгаа улам бүр алдагдаж байгаа нь түүний сэтгэлийн гол шаналан болсоор нэлээд жилийг үдэв. Цаашлах тутам байдал улам дордох нь ч тодорхой хэмээн тэрбээр уур савсан хөлрөх цонхны цаана сүүмэлтээх өөр айлын лааны гэрлийн ойтгыг ширтэн санаа алдана. Дулааны шугам хуучирч цоорсноос халаалт үе үе доголдон, элэгдэж муудсан станц цахилгааны хязгаарлалт хийж зутраах нь дасал болжээ.

2 Тээр жил Заяаг хотод ирж байхад ид засаглаж байсан хүмүүсийн үр хүүхэд, садан залуус мөн л түүн шиг насанд хүрч, амьдрал зохиосон ч эрс өөр дүр зургийг бий болгожээ. Тэд л өнөөдөр хөрөнгө баялгийн хуваарилалтыг алсаас болон шууд зохицуулан шийдэж, улс төрийн хувь заяаг хоорондоо тохиролцон, үе залгамжлан удирдах болсон нь эрх зүйчийн мэргэжил эзэмшиж, иргэний нийгмийн харилцааны дууч нь болж явсан түүний үеийнхнийг байнга гайхшируулж, улс орон нь хаана, хэзээ, яаж алдсаныг эргэцүүлэн суух шалтгаан болжээ.

Заяа дээд сургуулиа төгссөн жилээ ажил олж хийж чадалгүй, аахар шаахар жижиг компаниудад туслах, үйлчилгээний ажилд нь зарагдаж явсаар он дамжин шуугьсан Оюу Толгой, Таван Толгойн төслийн гэрээнүүд үзэглэгдсэн жилүүдийг үдсэн аж. Удалгүй инженер болохоор суралцаж байсан Орхонтойгоо танилцан нэг гэрт орсон нь саахан мэт. Уул уурхайн томоохон төслүүдээс асар их орлого орж ирнэ гэж шуугьсан 2012, 2013 онууд улиран одсон ч монголчууд тэр их орлогын барааг харсангүй. Харин оронд нь Монголын уул уурхайн ирээдүйд итгэж хөрөнгө оруулалт хийсэн гадаадын компаниудын нэхэмжлэлээр Монгол Улс байгуулсан гэрээ хэлэлцээрээ зөрчсөн гэх асуудлаар Олон улсын шүүхээр буруутгагдсан тухай сонстож эхэлсэн байна.

Заяагийн санаж байгаагаар 2012 оны сонгууль дахин мөнгөний сонгууль болж улс орны хувь заяа эргэлт буцалтгүй буруугаар эргэхэд хүрчээ. Бэлэн мөнгө амлаж улс орныхоо хөгжлийг баллахгүй гэж ам өчгөө өгсөн улс төрийн хоёр том хүчин хэлсэн үгэндээ хүрсэнгүй. Тэд сонгууль болохоос хоёр



Уул уурхайн хөрөнгө оруулагчид Монгол Улсад итгэхээ больж, хөрөнгө оруулалтын гэрээг цуцлах, өөрчлөх эрсдэлээс зайлсхийж хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, концессын гэрээ хүртэл байгуулахыг шаардах болжээ.

гуравхан хоногийн өмнө бие биетэйгээ өрсөлдөн Таван Толгойн хувьцааг иргэдэд шинээр нэмж өгөх, мөн бусад уул уурхайн том төслөөс хувьцаа эзэмшүүлэх, цалин тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж, бусад элдэв хөнгөлөлт, нөхөн олговор олгох амлалт ар араасаа хөврөв. Шинээр байгуулагдсан Засгийн газар сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэх сорилттой тулгарч Таван Толгойн хувьцааны үнийг индексжүүлэн иргэдэд олгосон нь сонгуулийн өмнө Таван Толгойн хувьцааг мөнгөжүүлэх замаар олгосон 1 сая төгрөгтэй хавсран инфляцийг хөөрөгдөж, юмны үнэ тэнгэрт хаджээ.

Сонгуулийн дараах зун ашиглалтад орсон Оюу Толгойн ил уурхайгаас олсон орлого УИХ-ын сонгуулийн бэлэн мөнгө тараах амлалтыг биелүүлэхээр 2012-2013 онуудад Рио Тинтоогоос урьдчилан авсан зээлийн өрийг буцааж төлөхөд зарцуулагдсан тул хөрөнгө оруулалт болж эргэлтэд орж чадаагүй юм. Уул уурхайн салбарын дэд бүтэц,

ханган нийлүүлэлт авилгад улам хүчтэй идэгдэж, тэр хэрээр компаниудын зардал нь өсөж төлдөг татвар нь буурлаа. Евро бүсийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр хөрөнгийн олноц хомсдож Оюу Толгой төслийн 50 хувийг төрийн мэдэлд авах шахалт шаардлага жижиг намууд болон иргэнийн худалдаачуудын зүгээс байнга тавигдах болсон нь Оюу Толгойн хөрөнгө оруулагчид далд уурхайд оруулах санхүүжилтээ азнаж, нөхцөл байдал хэрхэн өрнөхийг ажиглах шийдвэр гаргахад хүргэв.

Иймэрхүү нөхцөл байдалд Таван Толгойн нүүрсний уурхай дараагийн том бүтэлгүйтэл болж хувирав. Засгийн газар болон гадаадын компаниуд Таван Толгойн уурхайн нөөц, зах зээлийн үнэ, зардал, хөрөнгө оруулалтын өгөөж, ашиглалтын эрсдэлийн талаар өөр өөр ойлголттой байснаас санал зөрөлдөн Таван Толгойн ордын бүрэн хэмжээний олборлолтыг эхлүүлж чадаагүй юм. Эрдэнэс Таван Толгой л бага хэмжээний олборлолт явуулж байв.

Сонгогчдын бухимдлаас эмээсэн улс төрчид 2016 оны сонгуулиас өмнө гадаадын компаниудтай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээг шинээр хийх, дахин авч үзэх оролдлого хийв. Янз бүрийн нууцлаг этгээдүүд гарч ирж хувьцаа эзэмшүүлэхийг шаардах, заримдаа ил цагаан хахууль нэхэх болсноор гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хэн шийдвэр гаргаад байгаа нь ойлгомжгүй болсон аж. Ингэж тоглоомын дүрэм тодорхойгүй болсноос уул уурхайн компаниудын хөрөнгө босгох боломж эрс муудан хөрөнгийн хомсдолд орж эхэлсэн бөгөөд 2015 оноос шинээр хийгдэх хөрөнгө оруулалт зогсож, улмаар томоохон компаниуд хувьцаагаа зарж эхэлснийг тэр бүүр түүрхэн санах аж. Олон улсын төдийгүй Орос, Хятадын компаниуд Монгол Улсад итгэхээ больж, хөрөнгө оруулалтын гэрээг цуцлах, өөрчлөх эрсдэлээс зайлсхийхийн тулд хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, концессын гэрээ хүртэл байгуулахыг шаардах болжээ.

Ийнхүү жинхэнэ чөтгөрийн тойрог эхэлсэн юм. Дахин сонгогдохыг хүссэн улстөрчид сонгуулийг хөрөнгө оруулагчдаас урьдчилгаа их мөнгө авах арга хэрэгсэл болгож, ирээдүйд олох орлогыг барьцаалах болов. Сонгууль болгоноор баялгийн шударга хуваарилалтыг шаардах нийгмийн бүтэлгэлүүдийн шахалт зарим улстөрчдийн явцуу эрх ашигт нийцэн, гэрээг эргэн харах, Монголын талын оролцоог нэмэгдүүлэх саналыг тавьдаг болжээ. Олсон мөнгийг нэн даруй сонгогчдын саналыг худалдан авахад ашиглах болсон нь цаашид олох мөнгөний хэмжээг бууруулж, тэр хэрээр сонгогчдын улстөрчдөд итгэх итгэл улам бүр алдарч, нийгмийн дунд сэтгэл ханамжгүй байдал газар авав. Бэлэн мөнгө тараах тусам хүмүүс ажиллах хүсэлгүй болж ажлын байр шинээр нэмэгдэхгүй, өгөх мөнгөний хэмжээ багассан ч энэ мөнгөнөөс улам ихээр хамаарах аж. Бэлэн мөнгөний оронд Таван Толгойн хувийг хувьцаа хэлбэрээр иргэддээ дахин тараасан ч мөнгөний гачаалд гүн орсон ард олон эдгээр хувьцааг хэдхэн төгрөгөөр борлуулснаар цэнхэр ногоон тасалбар гэдэг шиг аанай л хоосон цаас болжээ.

Дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ 2012-2016 онд харьцангуй өндөр байсан ч Монгол Улс ийнхүү үүнийг ашиглаж чадаагүй юм. Харин 2018-2019 онуудад Европ, Америкийн эдийн засгийн шинэ хямрал эхэлснээр ашигт малтмалын үнэ унаж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үндсэндээ зогсжээ.

3 2020 он гэхэд төрийн санхүүгийн байдал багагүй хямралтай байв. Уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулах, зарим гадны компанийн олон улсын шүүхээр нэхэмжилсэн нөхөн төлбөр, иргэддээ том төслүүдээс эзэмшүүлсэн хувьцааг мөнгөжүүлэхэд зориулан Засгийн газрын авсан их зээлийн дарамт мэдрэгдэж эхэлсэн нь төсвийн алдагдал жилээс жилд нэмэгдэхэд хүргэв. Зэс, нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр ихээхэн унасан 2018-2019 онд энэ алдагдал 15 хувьд хүрчээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн алдаа завхрал гарч, зарлагыг дутуу тайлагнаж, мөн төсвөөс гадуур олон зардал гаргаж байсан тул санд

Дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ 2012-2016 онд харьцангуй өндөр байсан ч Монгол Улс ийнхүү үүнийг ашиглаж чадаагүй юм.

хуримтлагдсан мөнгө 2017 он гэхэд шавхагдсан байв. Хөгжлийн банкны бондын төлбөр нэхэгдэхэд банк өөрөө эргэн төлөх чадваргүй байсан нь төсөв дээр нэмэлт дарамт болж байв. Уул уурхайн их ирээдүйг бодолцон арилжааны банкууд их хэмжээний зээл гаднаас авч байсан нь эргэн төлөгдөх боломжгүй болж, төр хоёр ч банкныг дампууруулахгүйн тулд хөрөнгө оруулсан нь төсөвт таагүй нөлөө үзүүлж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг

хүчингүй болгоход хүргэв. Хөгжлийн банкаар жилд цөөн тооны төслийг санхүүжүүлэх ч гол төлөв үр ашгийн тооцоо муутай, улстөрчидтэй холбоотой компаниудаар дамжиж байв. Гадаад өрөө төлөх боломж хязгаарлагдмал, бонд гаргаад авах хөрөнгө оруулагчид байхгүй байсан нь Хятад улсаас нэмж зээл авахад хүргэж 2020 он гэхэд Монгол улсын нийт өр ДНБ-ий 150 хувьд хүрсэн нь 1990 оноос өмнө ОХУ-аас авсан их өрөөс ч илүү дарамтыг эдийн засагт үзүүлэх болов.

2021 он гэхэд Таван Толгойн уурхай дээр хамтран ажилладаг гадаадын голлох түнш нь Хятад улс болж, нүүрсний “зах зээлийн үнийг” ч тогтоож эхэлжээ. Тэрчлэн, Хятад өөрийн дотоодын зах зээлийн эрэлт өсөх хэрээр Монголтой хил залгаа нутагт хар, хүрэн нүүрсний олборлолтоо ихэсгэсэн нь Монголын нүүрсний экспортын орлого эрс буурахад давхар нөлөөлөв.

Монголын төрийн албан хаагчид болон Дэлхийн банкны шинжээчид улс төрийн намуудад Хятадын нүүрсний импорт багасна гэж анхааруулж байсан ч нүүрсний экспортоос олох орлогын хэмжээ огцом буурахад засгийн газар огт бэлтгэлгүй байлаа. Засгийн газар төсвийн их хэмжээний алдагдалд орж, ээлжит бэлэн мөнгөө тараахын тулд маш ихээр мөнгө хэвлэх болсноор инфляци хяналтаас бүрэн гарчээ. Инфляцийн хэмжээ 12 хувь байгаа мэтээр албан ёсоор зарлах авч үнэндээ 30 гаруй хувьтай байх болсоор удаж байгаа юм. Хувийн хэвцлийн компаниуд 10-аад жилийн өмнө уул уурхайн ирээдүйн орлогод найдан ихээхэн



2018-2019 онуудад Европ, Америкийн эдийн засгийн шинэ хямрал эхэлснээр ашигт малтмалын үнэ унаж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үндсэндээ зогсжээ.

хэмжээний зээл авсан нь даагдахааргүй дарамт болж, тэртэй тэргүй ихсээд байгаа үндэсний өрийн хэмжээг үлэмж нэмэгдүүлсээр байгаа юм. Дээр нь

зээл очих ёстой эзэндээ очоогүй бөгөөд банкууд улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын арга хэрэгсэл болжээ.

ОЛБОРЛОХ САЛБАРЫН ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ

Ил тод байдлын ач холбогдол

Монгол Улс нь байгалийн баялгийн тэсрэлт болж байгаа анхны орон биш юм. Канад, Чили, Норвеги, Орос, Казахстан, Туркменистан, Персийн Булангийн орнууд, Ангол, Конго, Ливи, Нигер зэрэг олон улс орон энэ замыг туулсан. Эдгээр улс орны иргэдийн хувь заяа өөр өөрөөр эргэснийг дэлхий нийт мэднэ. Манай улсын хувьд ч олдсон ховор боломжоо сайн ашигласан улс орнуудын эгзэгэнд орох баталгаа байхгүй бөгөөд иргэд л ил тод, харууцлагатай, үр дүнтэй байдлыг төр засаг болон хувийн хэвцлийн оролцогчдоос тууштай нэхдэг байж гэмээж нь баялгийнхаа үр шимийг хүртэх болно.

Уул уурхайн энэхүү тэсрэлтээс урт хугацаанд тогтвортой ашиг тус хүртэхийн тулд манай улс дараахь дөрвөн чухал хувьсагч хүчин зүйлийг тооцон үзэх хэрэгтэй болж байна. Үүнд:

- (1) Эрдэс баялгийн олборлолтоос хамгийн өндөр цэвэр ашиг хүртэж чадахуйц түвшинд ашиглалтын зөвшөөрөл олгох, гэрээ хэлцэл хийх чадвар;
- (2) Татвар болон бусад төрлийн орлогыг бүрэн хурааж, олсон орлогыг зарцуулах болон хадгалах хэрэгцээний оновчтой харьцааг тогтоож хуваарилалт хийх чадвартай орлогын менежментийн зохих бүтэц, байгууллагатай байх;
- (3) Макро эдийн засгийн тогтвортой байдал болон эдийн засгийн төрөлжилтийг хангасан, одоо болон ирээдүйн үеийнхний эрх ашгийг ижил тэнцүү харгалзсан, эрдэс баялгийг хүний сайн сайхан болгон хувиргах бодлого

боловсруулж, хэрэгжүүлдэг байх,
(4) Байгалийн баялгийн олборлолт болон эдийн засгийн өсөлтийн байгаль орчинд учруулах үр дагаврыг зөв удирдан хянах чадвар зэрэг болно.

Байгалийн баялаг, орлогыг хэрхэн зөв зохистой зарцуулдаг, тэрчлэн энэхүү баялаг, орлогыг төрийн болон хувийн хэвцлийн оролцогчид ил тод бус, үр ашиггүй, шударга бус замаар зарцуулж хэрхэн “өөрийн” болгодог талаарх олон орны туршлагаас сургамж авах боломж монголчууд бидэнд нээлттэй байгаа билээ.

Транспэрэнси Интернэшнл байгууллагын 2010 оны Авлигын индекс судалгаагаар Монгол Улс дэлхийн 178 орноос 116-т букуу нэлтэн доогуур жагсаж 10 онооноос 2.7 оноо авсан болно. 2015 онд байгалийн баялаг ихтэй бусад улс оронтой харьцуулахад манай улс дээрх жагсаалтын хэддүгээрт бичигдэх бол?

Норвег: 8.6 (#10)	Нигер: 2.4 (#134)
Чили: 7.2 (#21)	Туркменистан: 1.6 (#172)
Кувейт: 4.5 (#54)	

Орж ирэх орлогыг илүү ил тод, эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгэм, улс төрийн хувьд тогтвортой, улс орон илүү ардчилсан байх бүтэц, тогтолцоо, бодлогыг бий болгоход хөрөнгө оруулалт хийж зарцуулж болно. Мөн энэхүү орлого хэдхэн хүний халаасанд орох болон буруу зарцуулагдан үрэн таран болж ч мэдэх юм.

Гагарт Игнети, Javvelny, 2010, Getty Images



4

Олигархиуд Монгол Улсын бүрэн эрхт эзэд болжээ. Заяа нэгэн интернэт хуудаснаас 200 гаруй гэр бүл л Монголын эдийн засаг, улс төрийн намуудад хяналтаа бүрэн тогтоосон гэж уншжээ. Дэлхийн банкны статистик судалгаагаар Монголын хүн амын нэг хувь нь л жилийн нийт орлогын 45 хувийг, нийт хөрөнгийн 90 гаруй хувийг эзэмшдэг гэсэн дүн гарчээ. Олигархиуд олон нийтийн уур хилэн, шүүх цагдаа, төр засгаа үл тоох мэт авирлана. Ард түмэн ядуурал, гуйланчлал дунд амьдарч байхад эдгээр айл тансаг хурим, найр хийн баярхаж, зараа сувдан шигтгээгээр чимж, гийчид нь орон сууц, автомашины түлхүүр уралдуулан бэлгэнд өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь дуу нэгтэйгээр шагшин дуулж байсныг бодон эргэцүүлэхэд өнөөдрийн ийм байдалд хүрэхээс ч өөр замгүй байсан мэт.

Заяа, түүний найзууд хаана юу нь буруу болсноос ийм байдал үүссэн тухай үргэлж л ярьдаг. 2012 оны сонгуулиар гарч ирсэн хөрөнгөтнүүд өөрсдийн нөлөөг шургуу тэлж, тун удалгүй бүрэн ноёрхлоо тогтоож эхэлсэн аж. Цагдаа, аюулаас хамгаалах хүчин, цэргийн төсөв ихээхэн өсөж, боловсрол, нийгмийн үйлчилгээний хөрөнгө оруулалт, зардал навс унав. 2016 онд УИХ-д сонгогдсон хүмүүс тус тусын суудлаа өв залгамжлуулан үлдээх нууц тохиролцоог хийсэн гэсэн яриаг Заяа сонсжээ. Энэ нь муухан киноны зохиол шиг сонстох боловч энэ тохиролцоо аль ч хууль эрх зүйн баримтаас ч илүү тогтвортой биелэх болжээ. Шүүх засаглал ингэж найдвартай ажилладаг байсан ч болоосой гэж Заяа дотроо бодно.

Олигархиуд өөрсдийн эрх ашиг, албан тушаалыг хамгаалахын тулд юу ч хийхээс буцахгүй гэдгийг хүн бүр л мэддэг бөгөөд иргэний нийгмийн идэвхтнүүд, жагсагчид руу дайрах нь нийтлэг болсон бөгөөд үүнд цагдаа, бүр армийн анги нэгтгэлийг ашигладаг болсон аж. Аргаа барсан иргэд үе үе жагсаал тэмцэл хийх

авч тэдгээрийг зохион байгуулагчдыг нэг нэгээр нь, эсвээс хэсэг бүлгээр нь барьж хорих болсноос тэгсхийгээд үр нөлөөгүй төгсөх нь уль дол болжээ. Ангийнх нь найз Ирээдүй “улсын нууц” хулгайлсан хэргээр ахиад л шоронд орсон бөгөөд энэ нь хууль зүйн сайд болон Оросын бизнесүүдийн хоорондын хэлхээ холбооны талаар Орос улсад хэвлэгдсэн нэгэн мэдээг нэв хуудсан дээрээ тавьснаас болсон гэнэ.



Газар зүйнхр Т.Биевболор, 2012.

Төрийн хүчний байгууллагууд олигархиудад үйлчилдэг мэт болсон бөгөөд урд болон хойд хөршүүдийн хүчний байгууллагуудын “эвдлэхүүд”, мэдээлэгчид ажилладаг гэсэн яриа гарах болжээ. Гэсэн хэдий ч олигархиудын төлөө зүтгэх нь тийм амар, аюулгүй ажил бас биш юм. Өнгөрсөн шинэ жилийн баяраар Заяагийн нөхөр Орхон эздийнхээ шороон ордуудын нэгийг манан гэртээ ирээгүй бөгөөд дараа нь нүүр ам нь хавтгай болтлоо зодуулсан хүн гэртээ ирсэн байна. Орхон энэ талаар “Томчууд хоорондоо тооцоо хийгээд” гэснээс өөрийг дурдаагүй билээ. Бохир аргаар эрх мэдэлтэй болсон хүмүүс ямар ч аргаар өөрсдийгөө унахаас хамгаална гэдгийг Заяа ойлгох тул тэгсхийгээд дуугүй өнгөрсөн билээ. Хуульчдад аюултай байдаг тул Заяа алхам бүрээ хянаж явдаг. Олигархиудтай ямар нэг байдлаар хууль эрхзүйн хувьд шоргоолцсон хүмүүстэй Заяа

Монголын баруун бүс нутаг үндсэндээ уугуул ирээдээсээ өнчрөн үлдэж, хуурай сайр, говь цөлөрхөг хэсэг болжээ.



2012-2017 онуудад дэс дараалан болсон ган, хуурайшлын нөлөөллөөр цөлжин, байнгын урсгалт гол горхи ширгэж алга болсноос үүдэн өмнөд болон баруунаас төв рүү чиглэх нүүдэл ихэсжээ.

ажилладаггүй бөгөөд шүүхийн шийдвэр нь гэрээ, контрактын үндсэн дээр гардаггүйгээс хойш хийх нь утгагүй юм шиг гэрээ хэлцлийг боловсруулан цагаа өнгөрөөнө.

Баян болно гэж Заяа хэзээ ч бодож байсангүй. Харин хэзээ нэгэн цагт дундаж ангийн хэмжээнд сайхан амьдарна гэж бодож байсан үе Заяа болон Орхонд бий. Одоо энэ нь боломжгүй болжээ. Өнөөдрийн нөхцөл байдлаасаа зугтах арга зам түүний хувьд байхгүй мэт. Янз бүрийн судалгаагаар ажигчдийн түвшин 20 хувь, хүн амын 60-80 хувь

нь ядуу гэсэн дүн гардаг ч Нийгмийн Хамгааллын Яамны тоо баримт бодитой байдаггүй тул аль нь үнэн бодитой болохыг хэн ч мэдэшгүй. Дундаж орлоготой дундаж анги устаж алга болсноор Монголын нийгэмд хэт баяжсан цөөнхийн гадаад зах зээл, дэлхийд хандсан болон хэт ядуу дийлэнх олонхын үгээгүй, зогсонги дотоод зах зээл гэсэн хоёр зэрэгцээ эдийн засаг буй болжээ. Баруун бүс нутаг дэлхийн дулаарлаас үүдэн 2012-2017 онуудад дэс дараалан болсон ган, хуурайшлын нөлөөллөөр цөлжин, байнгын урсгалт гол горхи ширгэж

алга болсноос үүдэн өмнөд болон баруунаас төв рүү чиглэх нүүдэл ихэсж Улаанбаатарын хүн ам 2,5 саяд дөхсөн нь хотын эрүүл ахуй, хоол хүнс, дулаан цахилгааны хангамжид гэнэтийн цохилт болж, хамгийн хүйтэн, харанхуй, бохир, балмад хот болжээ. Орлогогүй олон иргэд ядуусын эгнээг тэлж, гэмт хэрэг, танхайрал ихэсж цэрэг цагдаагийн төсөв данхайж, сүүлдээ цагдаагийн байгууллагын оролцоо ихэссэнээр өнөөгийн цагдаажсан улсын төрхийг олсон нь ядуурлын гинжин урвалын үр дүн гэлтэй. Сүүлд Москвад очиход л аюулгүй байдлыг мэдэрснээ Заяа дурсах бүртээ нөхцөл байдал яагаад ийм болсныг гайхна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын өөрсдийн ажиллаж буй улс орны төр засгийн байгууллагуудад төлсөн аливаа төлбөрийг олон нийтэд ил болгохыг зорьсон, төр засаг, компаниуд, иргэний нийгмийн эрх тэгш оролцоог хангасан олон улсын санаачлага юм.

ОУИТБС-д одоогоор 35 орон нэгдээд байгаа бөгөөд тэдгээр орнууд ил тод байдлыг дээшлүүлэх замаар ард иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах гэсэн нийтлэг нэг алсын хараатай. Санаачилгыг хэрэгжүүлэх явцад компаниуд төлснөө, засгийн газар хүлээн авсанаа ил болгох, эдгээр тайланг хөндлөнгийн байгууллагаар хянуулж нэгтгэх, нийтлэх, хэлэлцүүлэг өрнүүлэхэд оршдог. Олон улсад ОУИТБС хэрэгжиж буй талаар www.eit.org вэб хуудаснаас үзэж болно.

ОУИТБС Монгол Улсад

2005 оны 10 дугаар сард Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хурлаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад Монгол Улс нэгдэх тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, энэ санаачилгад нэгдэх чиглэлийг Засгийн газарт өгсөн. Санаачилгыг дэмжих тухай Засгийн газрын 1-р тогтоолыг 2006 оны нэгдүгээр сарын дөрвөнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталж, Үндэсний зөвлөл байгуулагдсан.

Энэхүү Үндэсний зөвлөл нь зохион байгуулах, хянан зохицуулах талаар шийдвэр гаргах чиг үүрэгтэй, бүрэлдэхүүнд нь Засгийн газар, УИХ, компани, төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтдаг.

Байгуулагдсан цагаас хойш Монгол Улсын ОУИТБС-ын таван удаагийн тайлан гарч олны хүртээл болоод байна. Эдгээр тайлангийн дэлгэрэнгүйг <http://www.eitimongolia.mn> вэб сайтаас үзэж болно.

ОУИТБС-ын зарчмууд

ОУИТБС-ын зарчмуудыг 2003 оны зургадугаар сард Лондонд болсон ОУИТБС-ын анхдугаар бага хурлаар хэлэлцэн тохирсон юм. Улс орнууд, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын янз бүрийн бүлгүүдийн зүгээс олборлох салбар дахь төлбөр, орлогуудын ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн зарчмуудын мэдэгдлийг зөвшөөрсөн билээ. Эдгээрийг ОУИТБС-ын зарчмууд гэх болсон бөгөөд уг санаачилгын тулгын чулуу юм.



УЛААНБААТАР

Нийслэлийн хүн ам 2,5 саяд дөхсөн нь хотын эрүүл ахуй, хоол хүнс, дулаан цахилгааны хангамжид гэнэтийн цохилт болж, хамгийн хүйтэн, харанхуй, бохир хот болжээ.



Гарын үсгийг Jens Roesel, 2010. Photo.com agency

Ард түмэн ядуурал, гуйланчлал дунд амьдарч байхад олигархид тансаг хурим, найр хийн баярхаж, хурдан морь уралдуулан наадаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь тэднийг дуу нэгтгэжээр шагшин магтана.

Дэлхийн банкны статистик судалгаагаар Монголын хүн амын нэг хувь нь л жилийн нийт орлогын 45 хувийг, нийт хөрөнгийн 90 гаруй хувийг эзэмшдэг гэсэн дүн гарчээ.

5 Энэ удаагийн шинэ жилийн баярын гол төвөөр Заяагийнх ээлж таарсан бөгөөд гурван найз бүсгүй нь айлчлан ирэх дохож буйд оны зааг дээр бодлын хэлхээнд ийн автжээ. Хятадын зүүн нутагт ургуулсан хурдан ургацтай хүнсний ногоо Монгол айлын гал тогоо, хоолны жорыг бүрдүүлэх бөгөөд Солонгосын удаан хутацаагаар хадгалах зориулалттай хатаасан, лаазалсан хүнсний идэвхтэй хэрэглэгчид болсоор даруй арав шахам жилийн үджээ. Үндэсний хөрс шорооноо ургуулж өсгөсөн хүнсний олон олон жилийн өмнөөс сүйрсэн бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангаа дагаад мөн л байхгүй болжээ. Махны бодлогогүй экспорт, зах зээлийн монополь эрхийн төлөөх олигархидын тэмцлийн галд бүс нутгийн бэлчээрийн аж ахуй бусныг, генийн өөрчлөлттэй ургамлын тариалан Монголын эмзэг хөрс

шороог шимгүйтүүлэн атаршуулжээ. Бэлчээрийн тухай бүтэл муутай хууль гарсан нь бүүр нэрмэж, түүнийг тойрсон тэмцэл, өвөр хоорондын дайтал нь уламжлалт аж ахуйг сүйрүүлэх бас нэг том шалтгаан болсон аж. Малчид аргаа баран мал сүргээ зарж олноороо Улаанбаатарын захгаар суурьшин хашаа байшин, ойр зуурын хэрэглээнд сүүлийн хэдэн төгрөгөө барсаар ядуусын эгнээг өргөтгөжээ. Монголын баруун тал үндсэндээ уугуул иргэдээсээ өнчрөн үлдэж, хуурай сайр, говь цөлөрхөг бүс болсноор Хөвсгөл - Булган - Сэлэнгийн нутагт дийлэнх монголчууд нүүдэллэн ирсэн байна. Үлдсэн цөөн хэдэн жуулчны компанийн танилцуулгад Монгол бол нүүдэлчдийн орон гэж бичигдэх авч үнэндээ нүүдлийн соёл иргэншлээс ул мөр ч үлдсэнгүй. Архангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд эрх баригч эвсэлд хамаарагддаггүй учир аймагтаа хангалттай татаас, тусламж авч чадахаа болжээ.

6 Хаалга тогтносоор Заяагийн хүүхэд ахуйн унаган найзуудын нэг Ундраа салхи татуулан орж ирэнгээ өмнийн их элсэн далайг халааслаад ирснээ илтгэн инээх нь тод. Тэрбээр Сайншандын Үйлдвэрлэлийн цогцолборт ажиллаж өөрийн гэр бүлийн хүнийг даган говьд ажиллаж амьдардаг. Ходоо орон нутгийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ байгуулан арваад жилийн нүүр үзэж байгаа боловч сүүлийн үест явуургүй болсноо дуулгах болжээ. Олон улсын дундажтай харьцуулахад архны хэрэглээ болон эрэгтэй хүний дундаж наслалтын үзүүлэлт ихэд муудсан төдийгүй гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж, гэр хороололд сүрьеэ өвчин газар авчээ. Хүн амын тоог цөөхөн байлгах, хувь хүний хөгжлийг санаатай боож хаагуулах данд явуулга явагдах болсон хэмээн цуурхах нь зөвүүн. Санхүүжилтгүйн улмаас төрийн бус байгууллагууд сөхөрч, нийгмийн оршвхуйд иргэний нийгмийн оролцоо эрс хумигджээ. Төрөөс огох бага зэргийн санхүүжилтийг цөөн хэдэн төрийн бус байгууллага л авдаг бөгөөд ТББ-ын шивэгчилсэн бүртгэл явуулах нэрээр гаднаас санхүүжилт авдаг байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосон нь энэхүү байдалд нэрмээс болов. Гадаадын олон хандивлагч үйл ажиллагаагаа зогсоосон ч Ундраагийн ажилладаг чиглэлээр гадаадын хандивлагчид болон барууны сүмүүд тусламж өгсөн хэвээр байгаа тул бас ч гэж яахав. Иргэний нийгмийн байгууллагуудад иргэдийн оролцоо ихээхэн сул, тэдэнд үл итгэх нь элбэгшжээ.

Хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийн алдаатай бодлогоос үүдэн арваад жил дамнан үргэлжилж байгаа хүнд үйлдвэрийн цогцолборын байгуулалтад насаараа зүтгэж яваа эр нөхрөө бараадан хөдөөгийн элсэнд эерэгдэж дууслаа хэмээн Ундраа гомдоллоно. Эцсийн найдвар нь нээлтээ хүлээж буй хүнд металлургийн удаан түүхтэй, цагтаа зууны бүтээн байгуулалт хэмээн тунхаглаж байсан үйлдвэрт эр нөхөр нь гайгүйхэн албанд томилогдох явдал. Гэтэл хэн нэгэн олигархи үйлдвэрт өндөр хүүтэй зээл олгосон сураг дуулдах болсноор эзэмшлийн маргаан үүдэл энэхүү найдлага талаар болох аюул ч үүсжээ. Энэ бүх нөхцөл байдлыг Ундраа "таригүй нүхэнд унасан шаргачин шархаа долоож буй мэт" гэж тодорхойлно.

Уг нь тухайн үед уул уурхайгаас орж ирэх орлогыг төвлөрүүлэн тэргүүлэх салбаруудыг санхүүжүүлэх зорилготой байсан Хөгжлийн банкны хэрэгжүүлсэн төслүүдийн хамгийн бодитой нь энэ үйлдвэр болсон ч олон үр ашиггүй төслийг

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

ОУИПБС-ын зарчмууд

1. Байгалийн ноёд баялгийг ухаалаг ашиглах нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах нэг чухал хөшүүрэг хэдий ч зохистой удирдаж эс чаднаас нийгэм, эдийн засгийн олон сөрөг үр дагаварт хүргэнэ.
2. Байгалийн ноёд баялгийг иргэдийнхээ тусын тулд ашиглах асуудал тусгаар тогтносон улсын Засгийн газар анхаарлын төнд ямагт байх, үндэсний хөгжлийн эрх ашигт байнга нийцүүлнэ.
3. Ноёд баялгийг олборлосны үр шим нь олон жилийн туршид хуримтлагдах орлогын урсгалаар бий болох бөгөөд үнээс өндөр хамааралтай байна.
4. Засгийн газрын орлого, зарлагын талаар иргэд мэдээлэлтэй байх нь олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, хөгжлийн зохистой, бодитой хувилбар сонгоход тустай.
5. Төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулахад засгийн газар, олборлох үйлдвэрлэлийн компаниудын ил тод байдал чухал үүрэгтэй.
6. Ил тод байдлыг илүүтэй хангах үйл явц нь гэрээ, эрхийг хүндэтгэх хүрээнд хэрэгжих ёстой.
7. Санхүүгийн ил тод байдал дээшлснээр дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчин сайжирна.
8. Улсын төсвийн орлого, зарлагыг зохицуулах талаар засгийн газар иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх зарчим.
9. Нийгмийн амьдрал, төрийн болон бизнесийн үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын өндөр шаардлагыг нэвтрүүлэх.
10. Төлбөр, орлогыг ил тод болгоход цогц, уялдаа холбоотой, хэрэгжүүлж болохуйц хандлага, энгийн хялбар арга барил шаардлагатай.
11. Төлбөр, орлогыг ил тод болгоход тухайн улсад олборлох үйлдвэрлэл эрхэлж буй бүхий л компани хамрагдах ёстой.
12. Хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэхэд бүхий л оролцогч талууд, тухайлбал Засгийн газар, түүний харьяа агентлагууд, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, үйлчилгээ үзүүлэгч компаниуд, олон талт байгууллага, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч болон төрийн бус байгууллагууд чухал бөгөөд өөрийн чадавхид нийцсэн хувь нэмэр оруулах бололцоотой.

санхүүжүүлснээр банк өөрөө ч дампуураад байгаа юм. Дахиад л улсын өрийг нэмэгдүүлэх нэгэн шалтгаан болоод уджээ. Орлого байхгүйгээс болж данс нь олон жил улайчихаад байгаа Хөгжлийн, Тогтворжилтын сан гэх гоё, хоосон нэрс шиг юм үлдвэл яана гэж бодох зуураа Зана талх зүсэж зогсон. Хоосон дансыг нь олон жил хий хоосон цаасан мөнгө хэвлэх замаар аргалж байснаас үүдэн инфляци хэдэн зуун хувиар өсөж, өмнөх 10 жилийнхээс эрс өөр үнэ, тоо хэлэгддэг болжээ.

2018-2019 онуудад Европ, Америкийн эдийн засгийн шинэ хямрал эхэлснээр ашигт малтмалын үнэ унаж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үндсэндээ зогсжээ.

100.000 төгрөгийн үнэтэй талхаа 600-гийн талх шүү хэмээн инээлдэх тэдний наргиаг Заяагийн хүүхдүүд учрыг нь үл олох ч даган инээх аж. Төгрөгийн ханшны хэлбэлзэл айхтар савлагаатай тул юань л эцсийн дүндээ улс орны эдийн засаг төдийгүй айл өрхийн гал тогооны тооцооны дүнг нэгтгэж жиллэх болсоор уджээ.

Ундраа дунд сургуульд нийгмийн ухааны хичээл

заадаг Хингээ рүү залган яаруулахад багш нарын ажил хаях тухай цуглаанд сууж болзооноос хоцрох болсноо нөгөөх нь дуулгажээ. Хингээ бүтэлгүй гэрлэлтийн горьг нэгэнтээ амссанаас хойш гэр бүл зохиохоо хойшлуулсан гэж энэ хоёртоо хонигнодог ч хөнгөн гунигаар дүүрэн явдаг ажээ. Хингээгийн очсон цуглаанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн аль нь ч оролцоогүй тул хүмүүс санасан бодсоноо чөлөөтэй ярьж байлаа. Хингээ улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд газар орон, эрх мэдлийн төлөө хүч үзэж, бүр алага, хүчирхийлэл үйлдэхээс буцахгүй болж байгаа талаар хүмүүсээс сонссоноо найзууддаа ярилаа.

Найзууд цуглан зовлон гунигаа түр мартан хөгжилдөхөд гудамж, талбай ч гоёмсгоор гэрэлтэн цацах нь жаргал удаан байдаггүйг нотлох мэт. Хэт радикал, коммунист хандлагатай Шинэ Монгол Намын даргын зохион байгуулсан цуглаанд оролцсон Орхон бага зэрэг халчихсан шөнө дунд ирлээ. Орхоны “Би шинэ улс төрийн төлөө зүтгэхээр болсон” гэсэн эв дүй муутай үг нь хүүхдүүдийнх ирээдүйг жаргалаар бооцоолсон амлалттай тэнцэв. 2012 оноос хойш юу болсныг сайн санах тэрбээр энэ бол хүүхдүүдийнхээ ирээдүйг өөд татаж чадах хамгийн сайн зам гэж бодов. Магадгүй энэ бүх уул уурхайн баялаг олдоогүй байсан бол Монгол Улс хараалд өртөхгүй байсан байх гэж тэр бодож байлаа.



Photo courtesy: Jens Roelich, 2008. Photo: Jens Roelich

Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2016 он	2021 он
Нэг хүнд ногдох ДНБ (оны ам. долларар)	2,786.13	7,579.21	7,762.09
ДНБ-ий бодит өсөлт	15%	3%	1%
Уул уурхайн төсвийн орлого (сая ам.доллар)	733.82	1,944.54	1,327.15
Инфляци	11%	20%	12%
Ядуурлын түвшин	39%	30%	24.50%



Орлогын менежментийн үзүүлэлт		
Үзүүлэлтүүд	2011/2009 он	2021 он
Тогтворжилтын сан (тэрбум)	281	50
Хүний хөгжлийн сан (тэрбум)	0	0
Хөгжлийн банк (тэрбум)	50	0
Орлогын менежментийн индекс (Revenue Watch Institute, мүү-0; сайн-100)	38.2	33
Хөрфиндал индекс (0-1, 1-экспортын төвлөрөл маш их)	0.489	0.55



Засаглалын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2021 он
Шударга ёсны индекс (Global Integrity, мүү-0; сайн-100)	57	23
Банкнүүднээс зээлжих эрхийн зэрэглэл (S&P, 1-10, 10-эрсдэл их)	9	10
Өрсөлдөх чадварын зэрэглэл (World Economic Forum, нийт 142 улс)	98	110
Нээлттэй төсвийн индекс (Open Budget Partnership, мүү-0; сайн-100)	60	36

- ◁ 2012 оны сонгууль будлиантай явагдаж шивгээр байгуулагдсан УИХ иргэдийн итгэл, дэмжлэгийг хүлээж чадахгүйд хүрнэ.
- ◁ УИХ нь хөрөнгө мөнгө захиран зарцуулах эрхийн төлөөх сонирхлын бүлэглэлүүдийн тэмцлийн талбар болно. Эвсэл бүлэглэлүүд богино хугацааны ашиг сонирхлын үндсэн дээр үүсэж, тэр хэрээр түргэн задарна.
- ◁ Уул уурхайн салбарт ашиг сонирхлын хүчирхэг бүлэглэлүүд хяналтаа тогтооно. Гадаад дотоодын хөрөнгө оруулалттай компанийн аль нь ч тогтвортой, урт хугацааны хөгжлийн асуудалд анхаарал хандуулахгүй. Гадаад хөрөнгө оруулагчдаас авах татвар, төлбөрийг нэмэх, далд тохиролцоо хийх шахалт байнга нэмэгдэнэ. Богино хугацаанд олох ашгийг урт хугацааны ашиг сонирхлоос илүүд тавих байдал газар авна.
- ◁ Хөгжлийн банк, Тогтворжилтын сан зэрэгт их хэмжээний хөрөнгө төвлөрөхгүй. Оруулсан буцаах хөрөнгийг тодорхой бизнес, улс төрийн ашиг сонирхолд нийцүүлэн барьцална.
- ◁ Иргэдийн бүхмидийг мөнгө тарааж, татаас огчи, эсвэл хүчээр дарахыг оролддоно.
- ◁ Хууль дээдлэх ёс үндсэндээ алдагдана.
- ◁ Инфляци, үнийн цочмог өөрчлөлт, үндэсний өр зэргийг шийдэх бодлого, стратеги байхгүй. Гадаадын тээлтээс улам их хараат болж, өр тээлийг байгалийн баялгийг ашиглах эрхээр төлөх явдал нэмэгдэнэ.
- ◁ Гэмт хэрэг, ажилгүйдлийн түвшин өндөр болж, нийтийн эрүүл мэндийн асуудал хурцарна. Хөдөө орон нутагт эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээ хүрч чадахгүй.

ӨГӨӨМӨРТ НАЙДСАН МОНГОЛ ЗАЯА

Заяа өөрийнхөө болон хүүхдүүдийнхээ сар бүрийн тэтгэмж, нөхрийнхөө цалин зэргийг нийлүүлээд өдөр тутмын амьдралаа залгуулж, тун удахгүй нөгөө амласан сайхан амьдрал ирнэ гэж найдаад явж байлаа.

1

Нар нэлээд дээр хөөрсөн ч Улаанбаатарын дээгүүр нүүгэлтэх бараан үүлсийн цаанаас мэдэгдэхтэй үгүйтэй ёлтойно. Хаврын хавсарга борчуудын гэгдэх шавар шавхай болсон хорооллоос хог шороо хуйлуруулан дэгдэж хотын төвийн гял цөл болсон өндөр өндөр шигэн барилгуудыг хормын төдийд халтартуулах нь харамсмаар... Салхинаас өөр ижилсэх зүйлгүй эрс тэс энэ хоёр ертөнцийг нийтийн орон сууцны навсар хороолол зааглан оршино. Энэ хорооллын байшингуудын хот руу харсан талыг сайтар гоён будаж, цонхон доор нь нов ногоон хиймэл зүлэг суулгажээ. Харин эсрэг талынх нь хананых нь шавар энд тэндээсээ эмгэрч унаад хэзээ мөдгүй нурах гэж буй балгас шиг л харагдана.

Тэгтэл байшингуудын нэгнийх нь хамгийн хойд талын орцны хаалга чахран онгойж хөлдөө таарсан хог новшийг хайхрамжгүйхэн өшигчсөөр нэгэн эмэгтэй гарч ирлээ. Энэ бол Заяа. Нас дөнгөж гуч гарч буй боловч нэлээд оворжуу харагдах түүний араас дөрвөн хүүхэд нь цонхоор харан хоцорлоо. Сүүлийн 20 жилд хүн амын өсөлтийг дэмжихийн тулд төрөөс маш олон бэлэн мөнгөний хотолбор хэрэгжүүлсэн юм. Үүний үр дүн ч гарчээ. Заяагийн насан дээр дөрвөн хүүхэдтэй байна гэдэг тийм ч ховор үзэгдэл биш болсон. Монголын хүн амын өсөлт хамгийн оргил үедээ ирчихээд байгаа нь энэ.

Заяа арваад жилийн өмнө нэгэн дээд сургуулийг эрхзүйч мэргэжлээр төгссөн ч эхлээд ажил олдсонгүй. Ажиллаа ч гэж нэг их хайж яваагүй тул тэгсхийгээд мэдсэн сурснаа мартаж тийшээ хандав. Төгсөөд удаагүй байхдаа Орхон гэх монгол залуутай гэрлэж гурван ч хүүхэдтэй болсон ч тэр нь ажил хийхгүй, дээр нь сар бүр авдаг тэтгэмжийн мөнгөөрөө архи ууж, сүүлдээ өөрт нь гар хүрэх болсон тул аргагүйн эрхэнд хүүхдүүдээ аваад салжээ.

Ингээд хэдэн жилийн дараа нэгэн хятад хүнтэй сууж, дахин нэг хүүхэд төрүүлжээ. Төрөөс сар бүр өгдөг тэтгэмжийн мөнгөнөөс ихгүй цалин холстэй ажилд орох Монгол хүн бараг олдохоо байсан тул хятад ажилчдыг олноор нь авчирч суурьшуулсан юм. Үүнийг дагаад монгол эмэгтэйчүүд хятад хүнтэй гэрлэх нь хэвийн үзэгдэл болжээ. Заяа ч бусдын адил ажилтай, амьжиргаатай хятад хүнтэй сууж дундаж түвшинд дутагдах гачигдах зүйлгүй л амьдарч байлаа. Нөхрийг нь Жинэнь гэх бөгөөд Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт барилгын хятад ажилчдыг удирдан ажилладаг байсан инженер хүн л дээ.

Гэвч аавынх нь анхааруулан хэлж байсанчлан Заяагийн амьдрал нэг л өдөр хөмөрчээ. 2018 онд дэлхийн эдийн засгийн ээлжит хямрал эхлэхэд Монголын аж үйлдвэрийн паркт хийгдэж байсан хөрөнгө оруулалт зогсож, ажилгүй болсон Жинэнь сууж байсан байрнаасаа өөр ч юу ч үлдээлгүй тэднийг үнсэнд хаясан шалз шиг хаячихаад нутаг буцжээ. Заяад хийж чадах ажил байхгүйн дээр өөрөө ч ажил олж хийе гэж нэг их зүтгээгүй өнгөрсөн юм. Тэр үед эдийн засгийн хямрал нэг, хоёр сарын дараа зогсон, бүх юм хуучин хэвэндээ орж, Заяа ч төрөөс олгодог халамжийн мөнгөөр амьдралаа аваад явна гэсэн итгэлтэй байсан цаг. Гэтэл өнөөдөр эргээд харахад гурван жилийн өмнөх энэ итгэл найдвар нь биелээгүй бөгөөд амьдралаа залгуулахад улам л хүнд болж байх шиг санагдана.

Уг нь Монгол Улс 2009 онд байгуулсан уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээндээ өөрчлөлтгүй дагаж мөрдөх шийдвэрийг 2013 онд гаргаснаас хойш гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, сонирхол нэмэгдсэн юм. Ер нь Оюу Толгой, Таван Толгойн уурхайн ашиглалтад орж, Монголын

түүхэнд 2013 он бол Заяа шиг жирийн монгол хүмүүсийн хувьд хөгжил дэвшил тун ойрхон байгааг мэдрүүлсэн онцлог жил байлаа. Удахгүй Монгол Улс дэлхийн хөгжингүй орны нэг болж, ард иргэд нь зүгээр сууж байгаад л тансаг амьдрах тухай улстөрчдийн өдөр тутмын шахуу ярианд автсан энгийн ард иргэд ажил хийлгүй тэтгэмж аваад л хангалуун амьдрах хүсэлд автжээ. 2016 оны

УИХ-ын сонгуульд ялсан нам өмнөх сонгуулийн жишгээр бэлэн мөнгө амлаж, уул уурхайн нооцлын төлбөрийг урьдчилан авахаар тохиролцож чадсан тул хүүхдийн мөнгийг сард 300.000 төгрөг болгон нэмэгдүүлж, иргэн бүрт сард 500.000 төгрөг олгохоор шийдсэнээ зарлаж байсан нь түүнд саяхан мэт л санагддаг юм.

Тэтгэмжийн мөнгө уг нь амьдралд хүрэлцээд байдаг байсан ч хэдэн жилийн дотор тогроогийн ханш унаж, юмны үнэ огцом нэмэгдсэнээр байдал дордож буй нь мэдрэгдэж эхэлсэн. Үүнд бага зэрэг бухимддаг байсан ч Заяа өөрийнхөө болон хүүхдүүдийнхээ сар бүрийн тэтгэмж, нөхрийнхөө цалин зэргийг нийлүүлээд өдөр тутмын амьдралаа залгуулж, тун удахгүй нөгөө амласан

сайхан амьдрал ирнэ гэж найдаад явж байлаа. Гэвч гай газар дороос гэдэг шиг 2018 оны сүүлээр эдийн засгийн хямрал эхэлжээ. Аль 2013 онд байгуулсан Төсвийн тогтворжилтын сангийн мөнгийг эхлээд малчдад, дараа нь өндөр настан болон хүүхдүүдэд, сүүлдээ иргэн бүрт бэлнээр тараах хөтөлбөрүүдэд дайчлан шавхчихаад байсан тул энэ хямралтай нүүр тулахад ямар ч бэлтгэлгүй байсан Монголын эдийн засаг шууд сөхөрч эхлэх нь тэр. Эдийн засгийн хямрал гүнзгийрэн 2020 оноос зарим тэтгэмжийн мөнгийг багасгаснаас болж одоо улс орон даяар хүчтэй эсэргүүцэл орнож байгаа



Малчдын сана Чингис хаан сан болгон өөрчилж, иргэн бүрт сар бүр 500 мянган төгрөг, хүүхэд бүрт 300 мянган төгрөг өгөх журам гарчээ.

Газрын зураг: Б.Балбо-Очир, 2012.

билээ. "15.000 мянган төгрөгөөр нэг кило мах ч авч хүрэхгүй, хүүхдийн 300.000 төгрөг анх өгч байсан үеийнхээ 100.000 төгрөгтэй тэнцэх болжээ" гэсэн яриа хүн бүрийн амнаас унана.

Мөн тэтгэмжийн мөнгө багассанаар ихэнх нь амьжиргаагаа залгуулж чадахгүйд хүрээд байхад цөөн хэдэн хүн эдийн засгийн хямралыг ч анзаарахгүй болтлоо хөлжсөн тухай л их ярьдаг болжээ. "Монголын нийт хүн амын ердөө 2 орчим хувь нь л зүйрлэнгүй баян тансаг, 10-аад хувь нь чингэлэгдүү, 30 орчим хувь нь боломжийн цалинтай уул уурхай, түүнийг дагасан үйлчлэгч, барилгын салбарт ажилладаг дундаж анги гэж үзвэл хоёр хүний нэг нь халамжийн мөнгөнөөс шууд хараат ядуус юм" гэсэн мэдэгдлүүд энд тэнд байсхийгээд л болдог эсэргүүцлийн жагсаал цуглааны индэр дээрээс сүртэй гэгч хадна. Заяа энэ бүхнийг сонсохоороо өөрийн эрхгүй улс орныхоо сүүлийн 20 жилийн түүхийг эргэцүүлдэг. Байгалийн нооц баялгийнхаа ачаар сүүлийн 10 гаруйхан жилд дэлхийд гайхагдах их орлого олсон атлаа орлогын менежментийн тухай хүн бүрийн цээжинд ортол ярихаас хэтрэлгүй, орж ирсэн тэр их мөнгөө урт хугацааны тогтвортой хөгжил болгон ашиглаж чадаагүйг харамсана.

Саяхан өдөр тутмын нэгэн сонин дээр гарсан эдийн засагч нэгэн эрхмийн ярилцлагын талаар хүмүүс хаа сайгүй хэлэлцэн, маргах нь сонсогдоно. Тэрбээр Засгийн газар уул уурхайн салбараас жил бүр 6 тэрбум орчим ам.долларын орлого олж байгаа ч дийлэнх хувийг нь төсвийн урсгал зардал, бэлэн мөнгөний хөтөлбөр, үр ашиггүй дэд бүтцийн төслүүдэд ашигласан тухай тоо баримт дурдан тайлбарлажээ. Хөрөнгө оруулалтын сангаас санхүүжүүлж ирсэн томоохон төслүүд данцаа танил тал, улс төрийн хэлхээ холбоотой хүмүүсийн гараар орж чанар муутай, үр ашиггүй болж, хайран мөнгө салхинд хийсэж байгааг хурц шүүмжилсэн энэ ярилцлага Заяад хоёрдмол сэтгэгдэл төрүүлсэн юм. Улс орон даяар өрнөж буй сум, дүүрэг хөгжүүлэх барилгын ажлаас эхлүүлээд Тээврийн яамны сайдын төрсөн сумыг хөрш зэргэлдээ аймаг, сумдын төвтэй холбосон автозамын жишиг сүлжээ, Монголын нутгийг хойноос урагш нэвт дайран гарсан нарийн царилт төмөр зам зэрэг их бүтээн байгуулалтын ажлыг бодохоор огт юм хийхгүй байна гэж шүүмжилж боломгүй мэт санагдан өмөөрмөөр ч юм шиг... Өөрийнх нь дүүргээс сонгогдсон эрхэм гишүүн сонгуулийн амлалтаа биелүүлэхээр Хөрөнгө оруулалтын банкнаас мөнгө гаргуулан барьж эхлүүлээд дуусгаж чадалгүй

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

ОУИТБС-ын шалгуурууд

ОУИТБС-ын шалгууруудыг 2005 оны 3-р сард Лондон хотноо зохион байгуулагдсан ОУИТБС-ын хоёрдугаар бага хурлаар хэлэлцэн тогтсон юм. Орлоцгогч улс орнууд ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж байгаад тооцогдоход эдгээр шалгуурыг биелүүлэх, боломжтой бол бүр давж биелүүлэх шаардлагатай.

1. Газрын тос, хий, уул уурхайн компаниуд засгийн газарт төлсөн төлбөр, засгийн газар дурдсан компаниудаас авсан материаллаг орлогоо олон нийтэд хүртээмжтэй, цогц, ойлгомжтой хэлбэрээр байнга мэдээлнэ.
2. Энэхүү төлбөр, орлогод олон улсын стандартын дагуу хараат бус аудит хийгддэг байна.
3. Хараат бус, бие даасан алба төлбөр, орлогын мэдээллийг олон улсын аудитын стандартыг ашиглан нэгтгэх бөгөөд тайланд олж тодорхойлсон зөрүүг дүгнэлт, зөвлөмжийн хамт нь хэвлэн нийтэлж, ил болгоно.
4. Үүнд бүх компани, түүний дотор төрийн өмчит компаниуд хамрагддаг байна.
5. Энэхүү санаачилгын үйл явцыг төлөвлөх, хяналт үнэлгээ явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд иргэний нийгэм идэвхтэй оролцдог байна.
6. Тухайн улсын засгийн газар энэхүү санаачилгыг санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах бөгөөд шаардлагатай бол олон улсын банк санхүүгийн байгууллагуудын дэмжлэг авч, хэмжиж болохуйц зорилт, хэрэгжүүлэх хугацааг бүрэн тодорхойлох, дутагдах чадавхид үнэлгээ хийх ажлыг үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан байна.

орхисон газар доорх 5000 машины зогсоолтой асар том цэцэрлэгт хүрээлэнг санахаар харамсмаар ч юм шиг... Дэлхийн эдийн засгийн хямрал, ашигт малтмалын үнийн уналт зэрэг нь энэ хүрээлэнг барьж дуусгахад саад болоод зогсохгүй байраа томруулж, шинэ машинтай болох Заяагийн төлөвлөгөөг ч давхар давхар нурааж орхисон юм.



Хаврын хавсаргаа борнуудын гээдэх шавар шавхай болсон хорооллоос хог шороо хуйлруулан дээдэж хотын төвийн гял цил болсон өндөр өндөр шилэн барилгуудыг хормын төдийд халтартуулах нь харамсмаар... Салхинаас өөр ижилсэх зүйлгүй эрс тэс энэ хоёр өртөнцийг нийтийн орон сууцны нэвсгэр хороолол зааглан оршино.

2 Төв талбайд зарласан эсэргүүцлийн жагсаалд оролцогчид улам бүр нэмэгдсээр үд гэхэд талбай бараг шиг дүүрэн. Жагсагчид төв хэсэгт зассан тайзан дээр ээлжлэн гарч үг хэлж буй хүмүүсийн үгийг уухайлан давтах бөгөөд “Монгол хүн Монголдоо Европыхоос үнэтэй мах идэх ёсгүй”, “Байгалийн баялгийг ард түмний мэдэлд”, “Амлалтаа биелүүлж тэтгэмжийг нэм” гэх мэт уриа лоозон барьжээ. Заяагийн хувьд халамжийн мөнгөө

нэмүүлэх цорын ганцхан хүсэлтэй ч улс төрийн шинжтэй лоозонг ч уухайлан дэмжиж хоолойгоо сөөтөл хангирна. Зарим нь зах зайдуу газарт хэд гурваараа нийлэн архидах аж. Эргэн тойрны үнэт эдлэл, брэндийн дэлгүүрүүд бүгд хаалгаа хааж буу зэвсэгтэй хамгаалагчид гарчээ. Долоо хоногийн өмнө болсон ээлжит жагсаалын үеэр жагсагчид тэдгээр лүү дайран орж их хэмжээний дээрэм тонуул хийн, цэрэг цагдаагийн хүчээр тарааж ийнхүү хамгаалтад авсан юм. Талбайн баруун захад хэдэн арван хүн харин “Бэлэн мөнгөөр бидний

сайд Өгөөмөр индэр дээр гарч ирэв. “Баг бүрт өндөр хүчдэл, Сүл бүрт Мэгэйд жанрайсийг!” гэсэн уриатайгаар Архангай аймгаас УИХ-д сонгогдож улмаар хамтарсан засгийн газрын гишүүн болсон энэ залуу бол эрх баригч намын нөлөө бүхий гишүүн байсан хүний хүүхэд. Тэрбээр эцгийнхээ буянд өндөр хөгжилтэй оронд мэдлэг боловсрол эзэмшсэн бөгөөд ирээдүйтэй улстөрч гэгддэг нэгэн юм.

- Иргэд ээ! 2018 оноос хойш дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнэ 60 гаруй хувиар унаж манай улсын төсвийн орлого 54 хувиар багассан. Энэ бол манай төсвөөс 35 их наад буюу ДНБ-ий 28 хувьтай тэнцэх мөнгө дутсан гэсэн үг. Үүний улмаас бүтээн байгуулалтын томоохон төслүүдээ зогсооход хүрч, мөн иргэдэд олгодог бэлэн мөнгөний тэтгэмжийг бууруулахаас өөр аргагүй болсон...

- Үүүүүүү үүүү...
- Гэхдээ манай засгийн газар ард түмнийхээ төлөө бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажилласны үр дүнд иргэн бүрт одоо олгогдож буй хишиг, хувь дээр нэмээд улирал тутам 4 сая төгрөг буюу 1 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн тэтгэмжийг 2021 оны зургадугаар сард багтаан олгохоор шийдвэрлэлээ.

- Уухай, уухай...
Залуу сайд ийнхүү хэдхэн хормын дотор ардын баатар болон хувиралд индэр дээрээс бахдалтайгаар буув. Энэхүү мөнгөн тэтгэмжийг олгох гэж буй арга нь ямар хорлонтой болохыг Өгөөмөр мэдэж байлаа. Гэвч улс төр гэдэг ийм л хойно жалтай ч билээ.

Төсвийн орлого маш их өндөр байсан 2011-13 онд Тогтворжилтын санг байгуулсан ч тэр өвөл зуданд өртсөн малчдын шахалтаар малжуулах ажилд зориулж хүүгүй шахам зээл олгох Малчдын сан байгуулахад нөөцийг нь дайчлан Монгол улс “үүцээ задалж” байсныг залуу сайд сайн мэднэ. Малчдын сан удалгүй зорилгоо өөрчилж, бүх малчин өрхөд малын тоо толгойг нэмэгдүүлэх зээл олгож эхэлсэн нь хэтдээ бэлчээрийн доройтолд хүргэж, уул уурхайтай хавсран малчдыг бэлчээрийн нутаггүй болгосныг ч тэр мэднэ. 2016 оны сонгуулийн өмнө Малчдын санг Чингис хаан сан болгон өөрчилж, иргэн бүрт сар бүр 500 мянган төгрөг, хүүхэд бүрт 300 мянган төгрөг өгөх журмыг ч тэр санаачилж боловсруулалцсан билээ.

2013 оны орлогын түвшин хэвээр байсан бол энэ их тэтгэмжийг улс “үүрээд” гарах л байсан байх. Гэтэл урьд өмнөх улс төрийн амлалтуудаа биелүүлэх гэж уул уурхайн зарим орлогыг



Гарал зургийг С.Ч.Эвээс, 1911 он, Photoman agency



Гарал зургийг Jens Boveck, 2010, Photoman agency

урдчилж аваад хэрэглэчихсэн тул орлого буурч, дээрээс нь Хөгжлийн банкны төслүүд дампуурч Монгол Улсын зээлжих эрх буурсан тул аргагүйн эрхэнд Хятад улсаас 12 тэрбум юанийн зээл авч томор замын төслийг санхүүжүүлсэн. Түүгээр ч зогсохгүй 2020 онд бэлэн мөнгөний хөтөлбөрүүдээ зогсоохгүйн тулд 1,2 их наяд төгрөгийг Хятадаас нэмж зээлжээ. Уул уурхайн салбартаа хөрөнгө оруулалт хийлгүй явсаар одоо энэ салбарт

гадаадынхны ноёрхол тогтсон юм. Хятад ажигчид ихээр орж ирж байгаа нь дээрх зээлүүдийн гэрээний нөхцөл тул яалтай билээ. Асуудал үүгээр дууссангүй. 2020 оноос Монгол Улс гадаад орныхоо төлбөрт жилдээ 900 сая ам доллар төлж байгаа ч удахгүй үүнийгээ төлж дийлэхээ байх нь. Үүнд сэтгэл зовниж, бас энэ тухай Ерөнхий сайдад яаж мэдээлэх вэ гээд Өгөөмөр сайд толгой ганцгаж явна.

- Сайд аа, танаас зарим зүйлийг тодруулж болох уу?

- ...

- Төсвийн хэмжээг үүссэн энэ үед Тогтворжилтын сан яагаад үүрэгээ гүйцэтгэж чадахгүй байна вэ?

- Сүүлийн 10 гаруй жил бол манай улсын хувьд эдийн засаг эрчимтэй өссөн үнэхээр сэргэн мандалын он жилүүд байлаа. Бид уул уурхайгаас олсон орлогынхоо 70 гаруй хувийг нь хэрэглээг дэмжих болон ард иргэддээ тарааж амьдралыг нь дээшлүүлэхэд, 30 гаруй хувийг нь Хөгжлийн банкаар дамжуулан урт хугацааны дэд бүтцийн асар том төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглаж ирсэн. Үлдсэн өчүүхэн бага хувийг Тогтворжилтын санд хуримтлуулж байсан нь өнөөдөр хямралыг давахад хангалтгүй байгаа юм.

- Хөгжлийн банк үнэн хэрэгтээ дампуурсан гэсэн мэдээлэлүүд гадаадын хэвлэлүүд дээр гарсан. Энэ үнэн үү?

- Энэ бол ор үндэсгүй худал мэдээлэл.

- Хөгжлийн банкны мөнгөөр гадаадад авсан үл хөдлөх хөрөнгүүд нэр бүхий сайд нарын хувийн нэр дээр болсон байгаа талаар та юу гэж бодож байна?

- Энэ асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллага шалгаж байгаа.

- Засгийн газар ирээдүйн орлогоо барьцаалан их хэлжээний зээл авснаас сүүлийн жилүүдэд өрийн даралтад орж зээлжих зэрэгдэл нь эрс буурсан. Нийл үед гадаадаас мөнгө оруулж ирэх боломжгүй. Тэгэхээр саяын атласан 4 сая төгрөгийн тэтгэлжээ ямар эх үүсвэрээс олох вэ?

- Бид дотоод нөөц, бололцоогоо ашиглаж байгаа. Мөн манай олон жилийн найдвартай түншүүд туслалцаа үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлээд байгаа.

- Дотоод нөөц бололцоо гэдэгтээ та мөнгө хэвлэх аргыг хэлж байна уу? Ингэх юм бол тэртэй тэргүй өндөр байгаа инфляци хяналтаас гарч, хөрөнгө оруулалтууд зогсоод нэг төсөн сүйрэх биш үү?

- Хүнд хэцүү энэ цаг үед бид ажил хийж буй нэгнийгээ элдвээр шүүмжлэхийн оронд эв нэгдэлтэйгээр улс орныхоо төлөө ажиллах нь чухал байна. Уучлаарай, би одоо ажилтай тул ярилцлагаа дуусгах уу даа...

Үнэндээ Өгөөмөрт хэлэх үг олноогүй тул ярилцлагаа хурдхан дуусгахын түүе болжээ. Гадаад, дотоод эх үүсвэрүүд хаагдсан нийм үед татвар нэмэх, эсвэл мөнгө хэвлэх л арга байгаа бөгөөд татварын хувь хэмжээг нэмлээ ч аж ахуйн нэгжүүд даахгүй тул төсөвт орох орлого нэмэгдэхгүй байх магадлалтайг тэр намын хурал дээрээ

тайлбарласан. Харин намынхан нь татвар нэмнэ гэдэг бол өөрсдийнхөө халаас руу гараа дүрсэнтэй ялгаагүй хэрэг болох тул нөгөө аргыг нь нэгэлт сонгожээ. Бодлого, шийдвэр ниймэрхүү маягаар гардаг болоод ч тэр үү олон улсын судалгаагаар Монголын засаглалын үзүүлэлтүүд буурсаар л байна. Нийтийн эрх ашигт нийцэхгүй шийдвэр гаргах явдлын эсрэг тэмцэх ёстой сөрөг хүчин гэж байхгүй, нам дамнасан олигархи бүлэглэлүүд улс төрийг хянаж, иргэний нийгэм улстөрчдийн халаасны хүүхэддэй болж, ард түмэн нь халамжийн мөнгөөр тэжээлгэхийг урьтал болгосон хүлцэнгүй, идэвхгүй болсон нь 300 гаруй жилийн өмнөх Манжийн дарлалын үеийг эрхгүй санагдуулна.



Гарал зургийг Б.Басгалмаа, 2007.

Эдийн засгийн хямрал гүнзгийрэн 2020 оноос зарим тэтгэмжийн мөнгийг багасгаснаас болж одоо улс орон даяар хүчтэй эсэргүүцэл өрнөж байгаа билээ.

3 Өглөөний 06 цаг. Улаанбаатар хот. Өнөөх л шороон шуургатай саарал өглөө. Ирээдүй компьютерынхоо араас нүдээ нухлан босож ажилдаа явахад бэлтгэж эхэллээ. Түүний шөнөжин сууж хийсэн ажил бол таван одтой тансаг зочид буудлын хяналтын камеруудыг удирддаг ажилтай нь ямар ч хамаагүй www.ireedui.com вэб сайт юм. 40 гаруй насны энэ эр программ хангамжийн чадварлаг инженер. Тэр эх орондоо

мэт ажил хийж амьдрах гэсэн хоёр сонголттой сүүлийнхнийг нь сонгожээ. Яагаад нийм сонголт хийсэнээ тэр "Монголд мөнгө угаах, эсвэл богино хугацаанд их ашиг олохоор хөрөнгө оруулаад эдийн засаг муудахаар буцаж буй гадаадынхантай адил Монголын сэхээтнүүд бид эх орноо мөнгө тараахаар нь ирж авчихаад өнөөдөр хэрэгтэй үед нь хаяад явчихаж болохгүй" гэж вэб сайтдаа тайлбарлан бичжээ.

Түүний вэб сайт бол үнэндээ улс орныхоо явж буй зам мөр, ирээдүйд санаа зовнисон үзэл бодлынх



Гэрэл зургийг Б.Баясгалан, 2008.



Гэрэл зургийг Jens Roetzsch, 2008. Photoman agency

Төр засаг өр зээлээ дарахын тулд 47-р өргөрөгөөс хойш олборлолт явуулахыг хориглосон хуулийг нууцаар цуцлан гадаадын компаниудад лиценз олгожээ.

мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжүүлж дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх программууд зохиох мөрөөдөлтэй ч одоогоор зочид буудалд ажиллан гэр бүлээ тэжээнэ. Сардаа 3000 орчим ам.долларын цалин авдаг нь дундаж амьдрахад л хүрэлцдэг юм.

Ирээдүй найз нөхдийнхөө зөвлөснөөр гадаадад гарч мэргэжлээрээ ажиллах, Монголдөө энэ

нь индэр юм. Энд Ирээдүй шинг олон олон сэхээтэн нийтлэл бичиж, хэлэлцүүлэг өрнүүлдэг нь ихээхэн амжилт олж, хэдийнэ дундаж ангийнхны улс төрийн клуб шинг болжээ. Гэнч тэд аль ч нийгэмд байдаг сэхээтнүүдийн л адил ярьж бичихээс төдийлөн хэтэрдэггүй бөгөөд төв талбай дээр болж байгаа жагсаалд нэгдэн гудамжинд гарч тэмцэх нь зөв үү, буруу юу гэдэг талаар сүүлийн хэдэн

өдрийн турш мэтгэлцэж байгаа билээ. Вэб сайтын сүүлийн үед хамгийн их хандалттай байгаа бусад мэдээллийг гүйцэтгэн харвал:

- *Гадаадынханд найр тавьж стратегийн ордуудаа хувааж өгсөөр байх уу?*

- *Монгол Улс ундны ус импортлогч болоход хүрлээ!*

- *Нөхөн сэргээтийн мөнгөөр Хэрлэн, Орхон голууд дээр усан сан байгуулах төслүүд зогсож гол ч үгүй, нөхөн сэргээлт ч үгүй боллоо.*

- *Төр засаг өр зээлээ дарахын тулд 47-р өргөрөгөөс хойш олборлолт явуулахыг хориглосон хуулийг нууцаар цуцлан гадаадын компаниудад лиценз олгожээ.*

- *Олон улсын байгууллагуудын туслалжаар хэрэгжүүлсэн "Монгол Уушиг", "ДОХ-гүй Монгол" хотолборлуудын мөнгө авилгачдын халаасанд оржээ* гэх мэт гарчиг хөвөрнө.

Дундаж ангийнхны нийтлэг унаа болох дунд гарын жийпээрээ Ирээдүй ажилдаа явах замдаа нэгэн хувийн сургуулийн ахлах ангид сурдаг хүүгээ хичээлд нь хүргэж явна.

- *Миний хүүгийн шалгалт нүүлэг сайн уу?*
 - *Сайн. Энэ улиралд бүх хичээлдээ "А" гарч байгаа.*
 - *Ангийнх нь зугаалга нь гоё болсон уу?*
 - *Ёстой гоё болсон. Бидний замд гол таарсан.*

Жижигхэн ч гэсэн их хол урсдаг юм билээ. Даанч ус нь бохирдсон болохоор ууж, бас гаргаа угааж ч болохгүй гэсэн. Бид нар бас малчин айл үзсэн.

- *Аан. Миний хүү нөгөө хуулийн сургуульдаа юмаа явуулсан уу?*

- *Үгүй ээ. Хэчнээн сайн хуульч боллоо гээд хэзээ ч шүүгч болж чадахгүй юм чинь уул уурхайн инженер болохоор шийдсэн.*

- ...

Үдийн 13.00 цаг. Ирээдүйгийн ажлын ердийн нэгэн өдөр үргэлжилнэ. Хамт ажиллагсад нь үдийн цайндаа гарчээ. Байнгын үйлчлүүлэгч Өгөөмөр сайд буудлын тусгай өрөөнд сөрөг намын парламентын гишүүнтэй уулзаж байгаа нь хяналтын дэлгэц дээр харагдана. Алтаар бүрж доторлосон тансаг өрөөнд Франц тогоочийн бэлтгэсэн Австрали хонины мах зооглонгоо 100 жил дарсан үнэтэй дарс шимэн суух тэдний төрх байдал Арабын баячуудтай тун ч төстэй харагдана.

Ирээдүй техник төхөөрөмжүүдийнхээ ажиллагааг шалгаж байгаад уулзалтын өрөөнд байрлуулсан нууц микрофоныг санамсаргүй нээчихэв.

Гэтэл тэд ажил хэргийн яриа хэлцэл биш Сангийн ямнаас зарласан томоохон тендерийг хэрхэн луйвардах, авлигаа хэрхэн хувааж авах тухай үгсэн хуйвалдаж байх нь тэр. Уг луйвартаа Тогтворжилтын санд үлдсэн сүүлчийн мөнгийг авч ашиглах, эсвэл Хөгжлийн банкаар баталгаа гаргуулж эрсдэлийг улсад үүрүүлэх тухай ярина. Энэ бол эрх мэдэлд ойр албан тушаалтнууд хэрхэн хувийн ашиг хонжооны төлөө эх орныхоо ирээдүйг золиосолж буйн түгээмэл жишээ байлаа.

Улсынхаа төсөв санхүү, орлогын менежментийг гардан удирддаг сайд нь мэдэхгүйдээ биш санаатайгаар хувиа бодож байгаагаас л улс орон нь баялгаа худалдаж их мөнгө олохын хэрээр хөгжиж чадахгүй байгааг Ирээдүй ойлгов. Тэр бусдад ч гэсэн үүнийг ойлгуулахын тулд бичлэгийг ямар нэгэн тайлбаргүйгээр вэб сайтдаа орууллаа.

Оройн 18.00 цаг. Ажлаа таран гарч ирж буй Ирээдүйг хар хослол, нүдний шилтэй хоёр залуу тосон авав.

- Иргэн Ирээдүй, та бидэнтэй хамт явна уу.

"ТӨЛСӨН АВСНАА НИЙТЭЛ" БУЮУ ТАН ЭВСЛИЙН ТУХАЙ

"Төлсөн Авснаа Нийтэл" буюу иргэний нийгмийн ТАН эвсэл нь Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан юм. ОУИТБС-ын нэг онцлог бол түүний хэрэгжилт нь төр засаг, компани, иргэний нийгэм гэсэн гурван талын хамтын ажиллагаа, эрх тэгш түншлэлд тулгуурладаг явдал юм. Санаачилгын хэрэгжилтийн бүх үйл явцад эдгээр талууд ижил тэгш эрхтэйгээр оролцох ёстой. Тиймээс ч энэ үйл явцад иргэний нийгмийн байр сууринаас оролцох зорилготойгоор 2006 оны 10-р сард 17 бие даасан төрийн бус байгууллага нэгдэн тус эвслийг анх байгуулж байсан бол одоогоор гишүүн байгууллагын тоо 28-д хүрээд байна.

Эвслийн үйл ажиллагаа олборлох салбарын зүгээс татвар болон бусад хэлбэрээр төр засагт төлж байгаа бүхний л төлбөрийг ил тод болгоод зогсохгүй, хөрөнгө оруулалтын болон тогтвортой байдлын гэрээ, олборлох салбарын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн олголт, хяналтыг ил тод болгох чиглэлээр өргөжиж байна.

Өнгөрсөн хугацаанд ТАН эвсэл ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт идэвхтэй оролцон ажиллаж ирсэн ба санаачилгыг орон нутгийн түвшинд сурталчлах, ирээдүйн бодит оролцоог бий болгох, тэднийг чадавхижуулах,

үгэн зөв мэдээллээр хангах, зарим нэг уул уурхайн төвлөрөл ихтэй сумдад анхан шатны тайлан гаргах, гурван талт ажлын хэсэг байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг хийж ирлээ.

Цаашид үндэсний тайлангуудын мэдээллийг ашиглах, эргэлтэд оруулах, тайлангуудын мэдээллийг түүвэрлэн сорчилж аймаг, компани тус бүрээр гаргаж тухайн аймаг бүсэд амьдрагч иргэдэд мэдээллийг хүргэх, сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг засаг захиргааны анхан шатны нэгжийн иргэд, малчдад хүргэх, тэдгээрийн бодит оролцоог бий болгож, хянах, чанар үр өгөөжийг үнэлэх чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөөд байна.

Эвслийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.eiti.mn> вэб сайтаас үзнэ үү.



Хаяг: 2012 оны зохицуулагч байгууллага Хил Хязгааргүй Алхам ТББ, СБД, 8-р хороо. Мэдээлэл Технологийн Үндэсний Парк 311 тоот. Шуудангийн хайрцаг: УБ-20. м/х-416
 Утас: 99724869. Факс: 976-11-312989
 Вэб сайт: www.eiti.mn. Э шуудан: tan@mail.mn

4

Хөдөөд урин цаг хэдийгээ ирж хөвөнтэй дээлтэй явахад халууцахаар болсон ч бороо хур огт ороогүйгээс өвс ногоо цухуйх шинжгүй, уул толгод Улаанбаатарын гудамж адил зөгэл саарал өнгөтэй харагдана. Хамхуул хийссэн хөндий дундуур, хэн ч явдаггүй хурдны зам даган нэгэн хүн бараан морьтой гэлдрүүлнэ. Өдгөө 70 наслаг зооглож яваа энэ өнгөн бол өнөө цагт улам бүр мартагдан устаж буй нүүдлийн соёл, ахуй амьдралдаа үнэнч Монгол гуай юм. Нутаг усандаа мүйхар зөрүүдээрээ алдартай тэрбээр уулын мухар дахь гэртээ хөгшиноө үлдээж хэдэн малаа түр харж бай гэчихээд сумын төв орж тэтгэмжийн мөнгөө аван, хоол хүнсний зүйл базаахаар явж байгаа нь энэ.


Монгол гуай уул нь Өмнөговь аймгийн хүн л дээ. Гэтэл цөлжилтийн улмаас тэнд мал маллах аргагүй болсон тул бэлчээр ус бараадан энэ нутагт ирээд гурван жил болжээ. Хүн бүр Өмнөговьд суурьшиж илүү их халамж, тэтгэмж авахын тулд ар, өврийн хаалга хайн хооцолдож “Өмнөговийн ногоон карт”-ны төлөө амиа тавьж байхад тэндээс сайн дураараа нүүж ирсэн гэхээр түүний хэр зэрэг зөрүүд болох нь тодорхой. Нүүсэн цор ганц шалтгаан нь түүний хувьд малаа хариулах бэлчээр байсан гэдгийг сонсоод хүмүүс “тэнгэ”-ийг нь бүр ч гайхна. Учир нь өнөө цагт мал дагаж нүүдэллэн амьдарна гэдэг даяанчлан суугаа хуврагаас ялгаагүй тоост хорвоогоос тасарсан хэрэг юм. Тиймээс ч малчин гэхээр том хот дагасан фермийн аж ахуйн туслах ажилтан, эсвэл улам бүр ховордсон жуулчдын зам дагуу гэрт амьдардаг “Соёлын өвийг хамгаалах хөтөлбөрт” хамрагдсан хүмүүсийг л ойлгох болжээ. Монгол гуайн адил нүүдлийн мал аж ахуйг жинхэнэ утгаар нь эрхлэн буй цөөн айлын хувьд өөрсдийнхөө биш хотын баячууд, уяач улстөрчдийн малыг л хөлсөөр маллаж өгдөг юм.

Ерөнхийдөө Монгол Улсын мал

аж ахуйн салбарын дүр төрх нэг иймэрхүү бөгөөд уул уурхай, түүнийг дагасан үйлчилгээ, зугаа цэнгээн болон барилгын салбараас бусад бүх салбар хөгжсөнгүй. Эдийн засгаа төрөлжүүлж олон тулгууртай болгох бодлогыг эрх баригчид хэрхэн өөрсдодөө ашигтайгаар эргүүлдгийн сонгодог жишээ нь газар тариалан. Нэлээд хэдэн жилийн турш газар тариаланг дэмжих нэрээр төсвөөс асар их хэмжээний татаас олгосон боловч бүхэлдээ эрх баригчид болон тэдний ойр дотныхны мэдэлд байдаг компаниуд л бизнесээ өргөтгөж даххар даххар ашиг олсноос биш энэ салбарын өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдээгүй нь өдгөө Монгол мэтийн малчид хятад гурил идэж байгаагаас тодхон харагдана. Учир нь сүүлийн хэдэн жилд төсөв хямарснаас газар тариалангийнханд татаас өгч чадаагүй юм. Дээрх “Атрын 4, 5, 6-р аян”-уудаас гадна төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлж байгаа нэрийдлээр эрх баригчид өөрсдийн хувийн компани, нутгийн зөвлөлүүддээ олгосон мөнгө тоймгүй их. Энэ бүх үр ашиггүй хөтөлбөрийн эрсдэлийг төр л үүрснээс биш өөр хэн ч хариуцлага хүлээсэнгүй өдий хүрчээ.

Монгол гуай уйгагүй хөдөлмөрийнхөө үр шимээр бог, бод нийлсэн 500 гаруй малтай болсон нь олон малтайд тооцогдоно. Гэвч мах, сүү, ноос, арьс ширний бизнес фермүүд дээр төвлөрсөн тул малаасаа хангалттай ашиг орлого олж чаддаггүй. Тийм ч болохоор ахуй амьдрал нь тэтгэмжийн мөнгөнөөс хамааралтай хэвээр байна. Уул нь ямаа түлхүү үржүүлбэл ашигтай ч Монгол угийн “зөрүүд” зангийнхаа улмаас сүргийн бүтэцдээ ямааг 10 хувиас дээш гаргалгүй өнөөг хүрчээ.

...Сумын төв сарын өмнөхөөсөө ч цөөн хүнтэй болсон мэт хөл хөдөлгөөнгүй шахам. Захиргааны үүдэнд л тэтгэмжийн мөнгөө авах гэсэн хэсэг хүн шанаа. Харин урд нь тэтгэмжийн мөнгө олгодог байгаад санхүүгийн хямралын улмаас дампуурсан банкны



Монгол улсад уул уурхай, түүнийг дагасан үйлчилгээ, зугаа цэнгээн болон барилгын салбараас бусад бүх салбар хөгжсөнгүй.

ИТГЭЛ НАЙДВАР

Удахгүй Монгол Улс дэлхийн хөгжингүй орны нэг болж, ард иргэд нь зүгээр сууж байгаад л тансаг амьдрах тухай улстөрчдийн едөр тутмын шахуу ярианд автсан энгийн ард иргэд ажил хийлгүй тэтгэмж аваад л хангалуун амьдрах хүсэлд автжээ.



Facore Agency, Javix Research, 2007 Photo.com agency

салбар одоо архичдын цугладаг газар болжээ. Усны гачигдлын улмаас ажиллах боломжгүй болсон дутуу орхисон олон мянган хүний суудалтай бассейны дэврийг дамжин хэдэн хүүхэд хөөцөлдөн тоглоно. Цагтаа 5000 гаруй хүн амтай, төвдөө 500 шахам айл байсан энэ суманд одоо байгаа хүмүүс гэвэл бараг ингэсгээд болно.

Энэ суманд дутуу орхисон бассейнаас гадна төсөв баян байх үеийн үр ашггүй хоронго оруулалтын ул мөр нэлээд бий. 5000 хүний суудалтай соёлын ордон барихаар хотоос барилгын компани ирж, гурван жил дамнуулан хоёр ч удаа хоронго нэмж батлуулан барьсан ч дуусгалгүй хаяад явсан нь одоо балгас болжээ. Харин эмнэлэг, сургуулиудад оруулсан их хэмжээний хоронго оруулалт нь эрхбйн хүнд чиглэсэн юм болохоороо нэлээд хэрэгтэй юм болсон нь харагдана. Тухайлбал 1000-аадхан хүнтэй энэ сумын 10 жилийн сургуульд өндөр хурдны интернэттэй компьютерын лаборатори, англи хэлний лингафон танхим, зайны сургалтын тусгай өрөө гэх мэт байхгүй юмгүй.

Өдөржин халуун наранд явсаар ядарч туйлдсан Монгол өвгөн засаг даргын эхнэрийн ажиллуудаг гуанзанд арайхийн орж ирвэ.

- Алив хүү минь аяга цай хийгээд өгөөч.
- Цай байхгүй.
- Тэгвэл ядаж ус байна уу?
- Аяга ус 1 юань шүү дээ.
- Монгол мөнгөөр бол хэд гэсэн үг вэ хүү минь?
- Төгсгөл авахгүй ээ өвөө. Одоо чинь монгол мөнгө цааснаас ялгаагүй болчихоод байна шүү дээ.
- Арай ч дээ, Монгол хүн байтлаа аяга усаа... бүр хятад мөнгөөр зарах гэж үү?

Монгол гуай үгээ гүйцэд хэлж чадалгүй ухаан алдан уналаа.

...“УИХ, Засгийн газрын эрхэм гишүүн Өгөөмөрийн санаачлагаар байгуулав” гэсэн томоос том хаягтай сумын эмнэлэгт тэр ухаан орлоо. Даралт нь ихсэж ухаан алдсан гэнэ. Энэ ч яахав хэзээний нийм. Гэтэл эмч бүсгүй санаанд оромгүй юм дуулгав. Тэр ходоодны хорт хавдартай болжээ. Шалтгаан нь ундны усны бохирдол. Сүүлийн жилүүдэд хоёр хүний нэг нь үүгээр өвдож байгаа гэнэ.

Улсаас хоронго оруулсан бүхэн хий дэмий мөнгөний гарз болсонгүй. Үүнийг сумандаа өөрөө ч мэдэлгүй нарийн мэргэжлийн оношлогоо хийлгэсэн Монгол өвгөн анх удаа мэдэрсэн ч өвчин нь нэгэнт эмчлэгдэх найдваргүй болсныг сонсоод л харьжээ.

5 Заяа ер бусын баяртайгаар гэрээсээ гарч явна. Учир нь өнөөдөр тэтгэмжийн мөнгө буудаг өдөр. Энэ мөнгийг нэмүүлэхийн төлөө тэр хагас жилийн өмнө жагсаж тэмцэж явсан гэхээр бүр ч бахархмаар. Түүнээс хойш юмны үнэ хэд дахин нэмэгдэж амьдрал нь улам дорджээ. Гэхдээ л тэр үед мөнгөө нэмүүлж аваагүй бол бүр баларч байхгүй юу гэж бодохоор нэг л сайхан. Заяа Улаанбаатарын замбараагүй хот төлөвлөлтийн улмаас хэд зогссон ч 10 жилийн турш мөнгөөр зодон байж барьж дуусгасан шинэхэн метронд суун хэдхэн хормын дотор хотын төв орлоо.

Хэдий эрт босож ирсэн ч гэлээ АТМ-ийн гадаа хэдийнэ уртаас урт дараалал үүсжээ. Заяа замын ханшлага дээр эгнэн суух хүмүүсийн дунд нэг шар сонин барьж аваад тухлан суулаа. Сонин дээр “Кентакигийн морин уралдаанд анх удаа монгол морь түрүүлж Ерөнхий сайд 21 сая доллараар байлав”, “Эрүүгийн нөхцөл байдал улам дордож байна”, “Монгол Улс Гиннесийн номонд орсон аварга том шонхрын хөшөө босгов”, “Зарим ордны нөөцийг хэт ихээр худал зарлан мөнгө босгосон нь нотлогдон хөрөнгийн бирж үймээнд оров” гэх мэт гарчиг эрээлжлэн харагдана.

Тэгтэл түүнд нэгэн танил нь захидал авчирч өглөө. “Охин Заяадаа. Аав Монголоос нь” гэж монгол бичгээр таталган бичсэнгийг нь арай ядан гаргаж уншаад дугтуйг задлах үед гэнэт хуй салхи дэгдэн гар дахь захидалыг нь хийсгэн одлоо.

Заяа захидлын араас гүйж дарааллаа алдах эсэхээ шийдэж ядан зогсоор...

Хаврын тэнгэр мэт таахын аргагүй хувь заяандаа Заяа хэдийнэ эзэн нь биш болжээ. Бүх зүйлд бэлэн хариулт, бэлэн хоол хүртээд сурчихсан Заяагийн амьдралд хуй салхи мэт гэнэтийн оорчлолт хэрэгтэй гэж аав нь бичсэнгийг тэр мэдэх болов уу?



Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2016 он	2021 он
Нэг хүнд ногдох ДНБ (оны ам. доллараар)	2,786.13	10,063.23	11,637.85
ДНБ-ий бодит өсөлт	15%	2%	0%
Уул уурхайн төсвийн орлого (сая ам.доллар)	733.82	2,168.91	1,918
Инфляци	11%	25%	25%
Ядуурлын түвшин	39%	33.90%	45.20%



Орлогын менежментийн үзүүлэлт		
Үзүүлэлтүүд	2011/2009 он	2021 он
Тогтворжилтын сан (тэрбум)	281	0
Хүний хөгжлийн сан (тэрбум)	0	-200
Хөгжлийн банк (тэрбум)	50	0
Орлогын менежментийн индекс (Revenue Watch Institute, мүү-0; сайн-100)	38.2	30
Хөрфиндал индекс (0-1, 1-экспортын төвлөрөл маш их)	0.489	0.5



Засаглалын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2021 он
Шударга ёсны индекс (Global Integrity, мүү-0; сайн-100)	57	25
Банкуудын эзэлжих эрхийн зэрэглэл (S&P, 1-10, 10-эрсдал их)	9	9
Өрсөлдөх чадварын зэрэглэл (World Economic Forum, нийт 142 улс)	96	105
Нээлттэй төсвийн индекс (Open Budget Partnership, мүү-0; сайн-100)	60	25

- ◁ 2012 оны сонгуулиар санал худалдан авах явдал сонгуулийн үр дүнг тодорхойлно. УИХ-д томоохон шийдвэр гаргах улс төрийн хүсэл зориг дутна. Амар хялбар шийдлүүдийг урьтал болгоно. Тухайлбал,
 - ◁ Өмнө нь байгуулсан гэрээнууд хэвээр хэрэгжиж, шинэ гэрээнүүдийн хувьд урьдчилгаа төлбөр авах явдал нэмэгдэнэ.
 - ◁ Иргэдэд мөнгө тараах, татаас өгөх замаар дэмжлэгийг нь авахаг хичээнэ.
 - ◁ Бизнесийн бүлэглэлийн сонирхолд нийцсэн бодлого явуулж үндэсний эрх ашгийг орхигдуулна.
- ◁ Төрийн чадавхи сул. Төрийн албаны томилгоо танил талаар, янгуу ашиг сонирхолд нийцэн явагдана. Төрийн албаны нэр хүнд унана.
- ◁ Уул уурхайд шинээр дорвитой хоронго оруулалт орж ирэх нь зогсох ба гол төлөв гадаадынхан давамгайлна. Үндэсний чадахгийг бэхжүүлэх ажил орхигдоно. Салбарыг “мөнгөний үнээ” төдий харна. Ажлын байр тэр бүр нэмэгдэхгүй. Үндэсний оролцоо, өмчлөлийн тухай яриа чадал, нөөц боломжоос хамааран биеллээ олоогүй.
- ◁ Хөгжлийн банкны хоронго оруулалт улс төрийн шахалтаас шууд хамаарна. Хөгжлийн цэцэгтэй үндэсний бодлого байхгүй. Банкны сан хөмрөг хурдан хоосорч, төслийн санхүүжилтийг зээлийн өртөг өндөр гадаад эх үүсвэрээр хангахыг эрмэлзэх болно.
- ◁ Иргэд засгийн газрын тараах мөнгө, татаасаас хамааралтай болно. Бизнесийн салбарын өсөлт зогсоно. Бэлэнчлэх сэтгэлгээ улам бүр газар авна.
- ◁ Төсвийн тогтвортой байдлын хууль үнэн хэрэгтээ хэрэгжихгүй. Тогтворжилтын санд төвлөрүүлсэн хоронго хангалтгүй байсан нь үнэ огиом буурах эхний тохиолдолд л тодорхой болно. Төв банк хараат бус байдлаа алдаж засгийн газрын өрийг санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- ◁ Инфляци өндөр тул тогрогийн худалдан авах чадвар буурч, иргэдэд очиж буй татаас ч бодит дүнгээрээ багасна. Гадаад ор төлбөр үлэмж нэмэгдсэн нь юуны өмнө Хятадад төлөх ор зээлтэй холбоотой.
- ◁ Баялаг ихтэй ч чадавхи, засаглал сул оронд тооцогдох Монголд ядуу орны нийгмийн нийтлэг асуудлууд улам бүр тодорно.

ОЮУ ТОЛГОЙ

ӨМНӨГОВИЙН “НОГООН КАРТ”-НЫ ЭЗЭН ЗАЯА

Өвөр Монгол-Өмнөговийн эрчим хүчний цогцолборын Баруун Цанхи нүүрсний уурхайн мастер Заяа “Оюу Толгой” цэнгэлдэх хүрээлэнд улсын наадам үзэх эрхээр шагнуулжээ.

1

Өнөөдөр 2021 оны долдугаар сарын 11. Агаарын хэм сүүлийн зуун жилд тохиолдоогүй өндөрт хүрч халуун шатна гэж цаг уурчдын урьдчилан анхааруулсан энэ өдрийн бага үдэд Их Монгол улс байгуулагдсаны 815, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 110, Ардын хувьсгалын 100 жилийн тэгш ойгууд давхацсан Үндэсний их баяр наадам “Оюу Толгой” цэнгэлдэх хүрээлэнд ёслол төгөлдөр эхэллээ. Хэдэн жилийн өмнө уул уурхайн “Айвенхоу Майнз” компани Оюу Толгой дахь өөрийн эзэмшлийн 66 хувийг хэвээр үлдээх болзол тавьж хариуд нь 80.000 хүний суудал бүхий аварга том цэнгэлдэх хүрээлэгийг Монгол Улсад барьж өгөхөөр тохиролцсон юм. Гэвч анх товлосон Яармагт орон сууцны хороолол барьчихсан тул өөр газар хайж хэдэн жил болов. Ашгүй “Чингис хаан” олон улсын нисэх буудал Хөшөөтийн хөндий рүү нүүсний дараа Буянт-Ухаад өнөөх цэнгэлдэх хүрээлэгийг барьж энэ жилийн наадмаар нээлттэй нь давхар хийсэн юм. Ийн Монгол Улс багтаамжаараа Зүүн Хойд Азидаа БНАСАУ-ын Пхеньян хотын Майн нэгний нэрэмжит 150 мянган хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн, Бээжингийн 100 мянган хүний суудалтай “Шувууны үүр”-ийн дараа орох асар том цэнгэлдэх хүрээлэнтэй боллоо.

Түүнийг “Оюу Толгой” гэж нэрлэхийг анх “Дөчин мянгатын уугуул иргэд” хөдөлгөөн эрс эсэргүүцсэн ч 2018 онд ноос ноолуурын “Говь” компани түүхий эдгүй болж дампуурснаар “Оюу Толгой бол дэлхийд цорын ганц монгол брэнд” гэгдэх болсон тул тэгсхийгээд намжжээ.

Цэнгэлдэхэд дөхөхийн хэрээр “Оюу Толгой” тэргүүтэй уул уурхайн компаниудын нэрсийг гурван хэлээр урсгасан аварга том дэлгэцнүүд тэнгэр баганадаж аагим хурц нарнаас халхална. Ноднин УИХ албан байгууллага, аж ахуйн нэгжийн

Гарал зурвал: Б.Баясгалан, 2012.



албан ёсны нэр хаягийг кирилл үсгээр, шаардлагатай тохиолдолд англиар бичихийг зөвшөөрсөн хууль баталсан нь ийнхүү хэрэгжиж эхэлжээ. Гэвч уул уурхайн компаниудын ихэнх нь эхнээсээ англи, эсвэл латинаар галигласан хятад нэртэй болоод ч тэр үү mining, resource, coal, mineral, Beijing, Shinhua, Dachin зэрэг үгс эрээлжиж, хаа нэгтээ дундаас нь ханз үсэг ялгаран харагдана. Арваад жилийн өмнө ядахдаа нэр хаягийг монгол бичгээр бичдэг болъё гэж сүүлчийн удаа оролдлоод бүтээгүй билээ.

Өвөр Монгол-Өмнөговийн эрчим хүчний цогцолборын Баруун Цанхи нүүрсний уурхайн мастер Заяагийн ээлжийнхэн эхний хагас жилд 1 сая тонн нүүрс олборлож Бугатын гангийн үйлдвэрт ачуулсан тул улсын наадам үзэх эрхээр шагнуулж ирээд "Оюу Толгой" цэнгэлдэх хүрээлэнгийн "Өмнөговь" гэсэн бичигтэй тусгай индэрт байраа эзэлжээ.

Хэдхэн хоногийн өмнө шинээр сонгогдож, тангаргаа өргөсөн Монгол Улсын шинэ Ерөнхийлөгч Э.Чингис наадмыг нээж үг хэллээ.

"Би шинээр сонгогдсон Төрийн тэргүүний хувьд улс орныхоо өнгөрсөн, одоо, ирээдүйг өөдрөг сайхнаар дүтгэн хэлэхийг хүсэж байна.

...Монгол Улс уул уурхайн хүчирхэг гүрэн болж XXI зууны гурав дахь арван жилийн босгоор итгэл төгс алхан орж байна. Зарим хүн манай улсыг Монголиа бинь Майнголиа гэж магтах, зэмлэхийн завсарт хэлдэг. Эцэг өвгөдөөс үлдээсэн энэ уудам газар нутагтаа бурхнаас заяасан их баялагтаа эзэн болж үр шимийг нь хүртлээ гээд бид буруудах ёсгүй. Бид Монголиа ч мөн, Майнголиа ч мөн. Бид зөвхөн газраа ухаж баялгаа зөөдөг байсан тэр цаг улиран одож байна.

...2012 оны сонгуулийн дараа Дэлхийн банк, Ранд корпорацийн тусламжтайгаар уул уурхайн талаарх төрийн бодлогоо эргэн харж улсынхаа уул уурхайн ноёд баялгийн бүрэн дүр зургийг гаргаж салбарын хөгжлийн

Галсан зурвалж Ү.Одобоор, 2011.

Хүй долоон худагт уяачдын асар майхны оронд компаниудын гал нэртэй барилга байшин, чамин хотхон лиг дүүрсэн.



Зайсангийн амны хорооллын цаад энгэрийн модыг хяргаж нүцгэлээд баахан барилга босгожээ.

стратегиа оновчтой тодорхойлж чадсаны үрээр өнгөрсөн арваад жилийн уул уурхайн их орлогоор бид Сайншандад зэс, гангийн аж үйлдвэрийн иж бүрэн цогцолборыг барьж наадмын өмнөхөн ашиглалтад орууллаа.

...Манай засгийн газар олон улсын туршлагаас суралцан, уурхайн үйл ажиллагаа зогссоны дараа орон нутгийн эзэмшлийн болж үлдэх, өрсөлдөх чадвартай аж үйлдвэрлэлийг дэмжиж ажиллалаа. Уул уурхайн аж үйлдвэрийн төв зэрэг олон шинэ санаачлага бий болсны нэг нь оператор компаниуд болон орон нутгийн бизнес, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа сайжруулахад нь зориулж дэмжлэг үзүүлээ.

... Монгол Улс шатахууны хувьд гаднаас хамааралгүй улс болоход ойрхон байна. Үүний тулд Герман улстай хамтарч нүүрснээс хийн түлш гаргах үйлдвэрүүдийг Сайншанд, Шинэ-Овоод байгуулж үндсэндээ дууслаа. Арваадхан жилийн өмнө бид ОХУ-аас эрчим хүч импортлодог байсан бол өнөөдөр нүүрсний томоохон орд газруудад түвшилэн Ухаа худаг, Таван Толгой, Оюу Толгой, Нарийнсухайт, Хөшөөтөд цахилгаан станцуудыг амжилттай барьж байгуулсны ачаар БНХАУ руу илүүдэл эрчим хүчээ экспортолдог боллоо.

...Ийнхүү Монгол орны өмнөд хэсгийг бүхэлд нь багтаасан уул уурхай – эрчим хүч – хүнд аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийн бүс болгосноор Ази тивд Персийн булангийн орнуудын аж үйлдвэрийн бүстэй өрсөлдөхүйц хэмжээнд хүрч байна. 2018-2020 онд тохиолдсон дэлхийн эдийн засгийн хямрал, ашигт малтмалын үнийн эрс уналтыг бид чухамдаа уул уурхайгаас хуримтлуулсан Тогтворжилтын сангийн нөөцийнхөө ачаар давж чадлаа.

...Манай улсын нийт экспортод уул уурхайн эзлэх хувь 90 хувьд хүрч, эдийн засаг жил бүр өндөр хувиар өсөж, энэ үзүүлэлтээр бүс нутагтаа тэргүүлэх боллоо. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 15 мянган долларт хүртээ.

Би Монгол Улсын Ерөнхийлөгчийн

хувьд манай улс хөгжлийн шинэ зам дээр гарч ирснийг батлан хэлэх байна”.

Ерөнхийлөгч үг хэлж дуусаад тусгайлан зассан суудалдаа залрахад Заяа нэг нүдний, алганд багтахуйц жижигхэн дурангаараа түүнийг дагуулан дурандаж хоёр талаар нь эгнэн суусан УИХ-ын 99 гишүүн, Засгийн газрын 20 гишүүнийг нэгбүрчлэн харж танихыг оролдов.

Ерөнхийлөгчийн баруун гар талаас нэг хүн өндийж мэхийн ёслоод суусан нь Монгол Улсын Ерөнхий сайд Гэрэлт-Эрдэнэ. Тэр өнгөрсөн 2020 оны парламентын сонгуулиар хоёр том намын эвслийг удирдан ирэх дөрвөн жилд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг 20 мянган долларт буюу Өмнөговь аймгийн одоогийн түвшинд ойртуулах амлалт дэвшүүлж үнэмлэхүй олонхын санал авсан юм.

2 Наадмын бөхийн барилдаан гурав хоногийн өмнө эхэлжээ. Өчигдөр 2048 бөхийн урьдчилсан шалгаруулалт өндөрлөж үлдсэн аварга, арслан, гарьд, заан тэргүүтэй 256 бөх наадмын зүлэг ногоон дэвжээнээ дэвэн дэвсээр гарч ирлээ. Наадмын үндсэн барилдаан их шуурхай болжээ. Учир нь наадам үзэхээр ирсэн гадаадын зочид, жуулчид, ялангуяа цаг зав муутай хөрөнгө оруулагчдыг залхаахгүйн тулд бусад бөхийн төрлийн жишгээр нэг барилдааныг найман минутаас хэтрүүлэхгүй гэсэн дүрэмтэй болсон юм. Урд жилийн наадмаар Өвөрхангайн “Их Монголын хүчтэнүүд”, “Хөвсгөлийн хүчтэнүүд” дэвжээнүүдээс тодорсон хоёр шилдэг бөх энэ жил “Айвенхоу майнз” болон “Шинхуа МАК”-ын өмнөөс зодоглож үзүүр, түрүү хүртлээ. Хэнийг нь хэдэн тэрбумаар худалдаж авсан тухай жиг жуг наадамчин олны ярианы сэдэв болж байв.

Заяа маргааш нь соёолон насны морьдын уралдаан үзэхээр Хүй долоон худагт очлоо. Улсын



Сүхбаатарын талбайн чанх урдах модтой ирцэвэлэгийн оронд боссон «Chinggis Mall» дэлгүүрийн бараа чанартай ч тэнгэрт тулсан үнэтэй. Сүүлийн гурван жилд юмны үнэ дунджаар гурав дахин өссөн гэх албан ёсны мэдээ бий.

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТУНХАГ БИЧИГ

Байгалийн нөөцийн тунхаг бичиг бол төр засгийн газар, улс орнуудын байгалийн нөөц баялгаа ашиглах үйл ажиллагааг чиглүүлэх, эдийн засгийн эдгээр боломжийг иргэдэд хамгийн өндөр, тогтвортой үр ашиг авчрах байдлаар ашиглахад нь туслах зарчмуудын багц юм.

Энэ дүрэм нь засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагуудад улам бүр нөөц нь багасаж байгаа байгалийн баялгийг буруу зарцуулж, ашиглахаас сэргийлэх болон баялаг ашиглалтын үр ашгаа одоо болон ирээдүйд хүртэхэд нь туслах арга хэрэгсэл болж мэдлэг олгодог.

Энэ дүрэм нь нийм байх ёстой, тийм байх ёстой гэсэн нөхцлүүдийн болон мөн энэ нь бүх нөхцөл байдалд заавал таарч байх, тэгэх ёстой, ингэх ёстой гэсэн жагсаалт биш юм.

Түүнчлэн улс орнууд байгалийн баялгаа үр дүнтэй ашиглахад шаардлагатай бүтэц, зохион байгуулалт тийм байх ёстой, нийм байх ёстой гэж хэлж буй хэрэг ч бас биш юм.

Үүний оронд, дүрэм нь нийм бүтэц, байгууллагуудыг байгуулах, үйл ажиллагааг нь үнэлж, дүгнэхэд шаардлагатай ерөнхий зарчмуудыг зөвлөдөг билээ.

Энэхүү тунхаг бичиг нь засгийн газруудын өмнө тулгардаг чухал шийдвэр гаргах үйл явцад зөвлөгөө өгөх зорилготой арван хоёр үндсэн дүрмээс бүрддэг.

Эдгээр дүрмүүд нь юуны өмнө тухайн ашигт малтмалыг олборлох шаардлагатай юм уу гэдгээс эхлээд бий болсон орлогыг улс орны иргэдэд хамгийн ашигтай, хүртээмжтэй байлгах вэ гэдгийг шийдэх хүртэл үйл явцыг хамарсан байдаг.

Дүрэм бүрийг гурван түвшинд тайлбарласан байдаг.

- Үүнд:
- 1-р түвшин: Товч загвар;
- 2-р түвшин: Засгийн газруудын өмнө тулгардаг асуудлын талаар илүү нарийн тайлбар болон зөвлөж буй шийдэл;
- 3-р түвшин: Тулгарч буй асуудлын талаар техникийн буюу мэргэжлтийн түвшний яриа хэлэлцүүлэг байдаг.
- 4-р түвшиний мэдээллийг вэб хуудаснаас (www.naturalresourcecharter.org) авах боломжтой.



Газрын зургийг Д.Давсбаралт, 1942, Photo.com agency

наадамд албан ёсоор зөвхөн эрлийз морьд уралддаг болсон тул дүүхэлтсэн өндөр морьд тоос татуулан бариад оров. Айргийн тавд орсон соёлогчдын гурав нь УИХ-ын гишүүдийн, хоёр нь уул уурхайн компаниудын захирлынх байсан бөгөөд урьдынх шиг жийнээр биш 999-ын сорьцтой цэвэр алтан гулдмайгаар байлаа. Монгол морьд уяачдын наадмаар уралддаг сурагтай.

Наадамчид Хүй долоон худагт багтахыг больжээ. Уяачдын асар майхны оронд компаниудын гал нэртэй барилга байшин, чамин хотхон ниг дүүрсэн тул дараа жилээс Хөшөөтний цаахна морь уралдуулж байхаар шийдэж тийш хүрэх дөт зам тавихын тулд Богд уулыг хойноос нь урагш нүхлэх асар том бүтээн байгуулалтын ажил эхэллээ гэж сүүлийн хэдэн жилийн турш шуугилдсан юм.

Заяа буцах замдаа хотын төвөөс урагш харахад Зайсангийн амны хорооллын цаад энгэрийн модыг хяргаж нүцгэлээд дахиад баахан барилга босгосноос өөр юм үзэгдсэнгүй. Монгол Улс мөнгөтэй болох нь болжээ. Уул уурхайгаас жил бүр 4-6 тэрбум долларын орлого олж байгаа гэдэг. Түүгээрээ л эхлүүлсэн бололтой энэ мэт аварга бүтээн байгуулалт хаа сайгүй, даанч дуусдаггүй нь тоогүй. Метро барихаар Улаанбаатарын баруунаас зүүн тийш үргэлжилсэн урт хаалт нийслэлийг

тэг дундуур нь хуваагаад хэдэн жил өнгөрчээ. Эхний хоёр станц 2024 онд ашиглалтад орно. Бас Улаанбаатар - Мандалговь - Даланзадгадын хооронд төмөр зам тавина гэж тэндээс сонгогдсон УИХ-ын гишүүд баахан цамнаад эхлүүлсэн төмөр замын овоолсон шороо, далан эцэс төгсгөлгүй үргэлжилдгийг тэр саналаа.

Үдээс хойш Заяа Монголын хамгийн том дэлгүүр Chinggis Mall-оор орлоо. Сүхбаатарын талбайн чанх урдах модтой цэцэрлэгийн оронд боссон энэ аварга дэлгүүрийн бараа чанартай ч тэнгэрт тулсан үнэтэй болсонд Заяа цочирдсон ч Монголддоо хамгийн өндөр цалинтай, бас Өмнөговийн иргэний мөнгө авдаг нэрээ бодож өөртөө ганц хувиас, аав ээждээ гарын бэлэг авахад хэдэн саяыг зарцуулав. Сүүлийн гурван жилд юмны үнэ дунджаар гурав дахин өссөн гэх албан ёсны мэдээ бий.

3 Уг нь Заяа МУИС-ийн Хуулийн ангийг төгссөн ч гурван жил дараалан хуульчийн сонгон шалгаруулалтад өрсөлдөөд бараагүй юм. Зарим найз нь “Чи эхлээд томхон ниг намын сонгуульд яв, намд нь элсвэл бүр сайн” гэж битүүхэн зөвлөснийг үл тоосныхоо горьг амсаж буйгаа



Газрын зургийг Б.Тэмүүлэн, 2010.

хожим ойлгожээ. Ингээд мэргэжлээ солихоор шийдэж Нүүрсний технологийн их сургуульд элсэн орж ил уурхайн инженер болоод Өмнөговийг зорьсноос хойш жилдээ нэг нутагтаа очдог болсон юм. Энэ удаад наадмаар амжиж аав ээжтэйгээ золгохоор өглөө эртлэн босож хурдан галт тэргэнд суугаад Сайншанд хүрч тэндээсээ Дорнод Монголын төмөр замаар Сүхбаатар аймгийг зорилго.

Заяа купендээ хоёулхнаа явна. Тун цөөхөн хүн зорчих ажээ. Таван Толгойн нүүрсийг зүүн зүгт зөөж Оросоор дамжуулан Номхон далайн боомтуудад хүргэх учиртай энэ төмөр замыг дэндүү их өртгөөр боссон, ашиггүй гэхчлэн хүмүүс элдвээр шүүмжилдэг ч Заяа харин тэгж бодож байсангүй. Аав ээжтэй нь уулзуулдаг болохоор арга ч үгүй юм даа.

Үдээс хойш төрсөн нутгийнхаа хилийн дээсийг давлаа. Галт тэрэгний цонхоор янз бүрийн уурхай, жижиг суурин тосгод жирэлзэн өнгөрөх авч хүүхэд ахуйд нь хаа сайгүй багшран харагддаг байсан мал сүрэг, хэдэн мянгаараа цахилах зээрийн сүргийг Заяа хоёр нүдээ чигтэл харуулдаад олж үзсэнгүй.

Аймгийн төв өнгөрөөд Сүхбаатар өртөөн дээр буухад аав, ээж, дүү гурав нь тослоо. Тэднийх Түмэнцогтын айл боловч өнгөрсөн жилийн зуднаар

малынхаа ихэнхийг тавиад туучихсан тул энэ хавар төмөр зам бараадан энд суурылжээ.

“Охиныхоо явуулсан мөнгөөр авсан юм. Хийн хөдөлгүүртэй гээч” хэмээн аав нь шинэвтэр япон машиныхаа дугуйг нэг сайн өшиглөөд тэднийг суулган хөдлөв.

Энэ өртөө баахан солонгостой болжээ. Хоёр жилийн өмнөх хоёр Солонгосын мөргөлдөөний үеэр НҮБ-ын шийдвэрээр Монгол Улсад Хойд Солонгосын 30 мянган дүрвэгчийг түр байрлуулсны нэг хэсэг энд суурылж одоо бүр цементийн үйлдвэр барьж эхэлсэн ажээ. “Манайхан эд нартай яаж ийгээд холбогдох юм. Өвөө чинь хотод 1950-аад онд БНАСАУ-аас авчирсан өнчин хүүхдүүдийн цэцэрлэгт манаач хийдэг байсан гэж ярьдаг сан. Гэтэл одоо аав нь энэ солонгосчуудад мах нийлүүлж байдаг. Дүрвэгсдийн хороо гайгүй үнээр гэрээ хийдгийг нь бодоод л зуднаас үлдсэн хэдэн малаа өгч байна” гэж аав нь зам зуур ярьсаар өртөөнөөс холгүй байх гэртээ ирлээ.

Аавынх нь гэрээ буулгаж хураагаад канад технологийн байшин барьж оржээ. Заяа хөдөөний амьдрал ямар өөр болсныг сая л анзаарав. Олон малтай айл ховорджээ. Мянган малтай айл нүдний гэм болсон тул “таван зуут малчин” гэдэг өргөмжлөл өгдөг болсон гэнэ. Хээр талаар морьтой

хүн явах нь цөөрч энд тэндгүй элдэв машин тэрэг хөлхөнө. Аав нь “Одоо бензин хайхаа больсон шүү. Энд цэвэрлэдэг станц байгуулснаас хойш ёстой амар байна” гэлээ. Бас нэг содон мэдээ дуулгасан нь түүний төгссөн Түмэнцогт сумын сургууль, хорвоод мэндэлсэн сумын эмнэлэг хоёрыг нь хаасан гэнэ. Засаг захиргааны шингэлэл хийж тэндхийн захиргаа, эмнэлэг, сургуулийг эндхийнхтэй нэгтгэжээ.

4 Заяа аавындаа хоёр хоноод буцлаа. Замдаа Сайншандад амьдардаг, ангийн найз Гэрлээ рүү утсаараа дүрст дуудлага хийж тосож уулзахыг хүсэв. Уулзаагүй удсан хоёр найз төдөлгүй дуу алдан тэврэлдэж элдэв ярианд умбах нь тэр.

“Манай Сайншандад том том үйлдвэр баригдаж хүн амьтан бужигнаад сайхан л байна. Гангийн үйлдвэрийнхэн 3-4 саяыг авдаг гэсэн. Түүнийг дагаж юмны үнэ өсөөд л... Над мэтийн багшийн цалин чирэгдээд байх юм” гэж найз нь зөвлонгоо ярилаа.

- Танай нөхөр юу хийдэг билээ?
- Солонгосоос ирээд “Дорнын говь” махны үйлдвэрт орсон чинь чүүтэй чайтай хоёр саяыг өгдөг. Танай уул уурхайнхны хажууд ичмээр байгаа биз дээ. Найз нь нэг юм асууя. Бид хоёр танай Цогтцэцэйд очвол тэр хавиар уурхайд гайгүй ажил олдох болов уу? Бас танай Өмнөговийн иргэн бүрт

сар болгон өгдөг 1000 ногооныг авдаг болчихвол ч ...

- Шуудхан хэлэхэд хэцүү дээ. Сая аавынд очиход энэ хавар сургуулиа төгссөн ногоо Батаа дүү маань дээд сургуульд орохгүй, Өмнөговьд очно, байнгын оршин суугчийн “ногоон карт” олж өг гэж шалаад салдаггүй ээ. Яаж олдох вэ дээ. Сүүлийн хэдэн жил наанаас монголчууд, цаанаас хятадууд шаваад өөр айлгийн хүтүүсийг ажилд авахгүй хязгаарлаад байгаа... Чи хятад хэлтэй юу?

- Юу гэж? Миний англи хэл гайгүй юмсан.
- Сая манай Засаг дарга захирамж гаргаж Хятадын компаниудад хятад хэлний орчуулагчийг өөр газраас авахыг зөвшөөрсөн.

- Тэгвэл хятад хэлний дамжаанд суух уу? За ямар ч байсан найзыгаа мэдэж байгаарай...

Хагас цагийн дараа Заяа дараагийн галт тэргэнд суув. Тэр оройдоо Цогтцэцэйд буухад нөхөр Баяраа, гурван настай хүү нь тосож авлаа. Тэд оройжингоо наадмын сонин хачин хөөрөлдөв. “Улаанбаатарын шинэ цэнгэлдэх гоё юм уу? Чамайг эзгүйд хүү бид хоёр Даланзадгад орж Өмнөговийн наадмыг бас шинэ цэнгэлдэхэд үзсэн. “Ухаа худаг” нэртэй. “Энержи ресурс” барьж өгсөн гэнээ. Өмнөговийн наадам мундаг болох юм аа. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их хурлын дарга гурвуулаа ирснийг сонссон биз дээ. Томчууд бүгдээрээ хувийн ивэсдэг тэргээр, морьдоо ачааны онгоцоор авчирсан шүү дээ” гэж Цогтцэцэй хотын ерөнхий эмгэлгэний эмч нөхөр нь ярилаа.

5 Баяраа уул нь Архангай аймгийн хүн. Арваад жилийн өмнө аав, ээжийн хамт Улаанбаатарт нүүж ирээд хотын хүн болжээ. Анагаахад сурч байхдаа Заяатай танилцаж гэрлээд түүнийгээ дагаж Цогтцэцэйд ирсэн юм. “Би говьд ирсэн ч Орхон голынхоо усаар ундаалдаг” гэж ярих дуртай. Тэр нь ч үнэн л дээ. 2010-аад оны эхээр Оюу Толгой, Таван Толгой ашиглалтад орж хөрсний усыг их хэмжээгээр соруулснаас 2018 он гэхэд Өмнөговь аймаг бараг тэр чигээрээ усгүй болж хангайн гол мөрний усыг нааш татах хэдэн зуун тэрбумын өртөгтэй төслийг маш яаралтай хэрэгжүүлэхээс өөр аргагүй болсон юм. Ингээд 2019 онд мянга гаруй километрийн зайтай орших Орхон голын усыг хоолойгоор татан Цогтцэцэйд авчирчээ. Гэхдээ ихэнхийг нь уурхайд ашигладаг юм. Яг тэр жил бас Хэрлэн мөрний усыг Ханбогд сум руу, үнэн хэрэгтээ Оюу Толгойн уурхай руу урсгах болсон билээ.


Чухам энэ төслүүд Монголын иргэний хөдөлгөөнийг дахин сэргээлээ. Гол мөрний усыг уул уурхайд ашиглахыг эсэргүүцдэг, цаашлаад уул уурхайг ширүүн шүүмжилдэг “Орхон голоос савраа тат!”, “Уул уурхайг хазаарлаа”, “Бэлчээрээ аврах малчдын фронт” зэрэг олон байгууллага гарч ирлээ. Тэдгээрийг анх Архангай, Өвөрхангай аймагт гол усны эрэгт алт олборлож байсан компаниуд болон шинжа нарын эсрэг олон жил тэмцэж, арваад жилийн өмнө буу шийдэмдээ хүрч

орон шоронд орж байсан Өнөбаяр, Магнайдорж, Тайвантөр нарын нөхдүүд толгойлдог юм. Саяхан тэд хэлтэлийн бага хурал зарлаж эрх баригчид Завхан, Ховд голууд төдийгүй бүр Хөвсгөл, Увс нууруудын усыг хүртэл баруун бүс нутгийн цөлжилтийг бууруулахад ашиглах нэрийн дор фосфорит, нүүрсний уурхай, тэдгээрийг түшиглэсэн үйлдвэрүүдэд нийлүүлэх арга замыг далдуур хайж энэ талаар гадаадын нэг улстай нууц хэлэлцээр хийж байна гэж мэдэгдсэн билээ. Нэрээ нууцалсан эх сурвалж тэр улсыг Солонгос гэжээ.

Энэ хавар дээр дурдсан хөдөлгөөнүүдийн тэмцэл бүс нутгийн шинжтэй болж, тухайлбал ОХУ-ын “Спасём Байкал”, “За полноводную Селенгу” зэрэг олон нийтийн байгууллагуудтай хамтарч эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулсан нь Орхон голын усыг олон жил бөхирдуулж, мөн их хэмжээний усыг Монголын өмнөд нутаг руу урсгаснаас түүний цутгадаг Сэлэнгэ мөрний урсац эрс татарч, улмаар дэлхийн цэнгэг усны хамгийн том ноогийг агуулдаг Байгал нуурт нөлөөлөх хэмжээнд хүрсэнтэй холбоотой юм.

Байгаль хамгаалах асуудал зөвхөн уул уурхайгаас болж хурцдаагүй. Сүүлийн арав гаруй жилийн турш асар их мөнгө цутгасан атрын аянууд (энэ жил 6 дахь аяныг зарлажээ) олонтой үр дүнд хүрсэнгүй. Үр тарианыхаа дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чадаагүй нь бага хэрэг. Төв, Сэлэнгэ, Булган аймгийн үржил шимтэй газруудыг хяналтгүй хагалснаас цөлжилт улам нэмэгдэж

БАЙГАЛИЙН НӨӨЦ ИЙН ТУНХАГ БИЧИГ



Дүрэм (эхний түвшин)

- 1) Байгалийн баялгийн олборлолт ашиглалтыг тухайн баялгийн эзэн орны иргэдэд дээд зэргийн үр өгөөжтэй байхаар боловсруулсан байх ёстой.
- 2) Олборлосон баялаг бол нийтийн өмч бөгөөд түүнийг олборлож ашиглахтай холбоотой шийдвэрүүд ил тод байж, олон нийтийн мэдээлэлжсэн хяналтад байх ёстой.
- 3) Өрсөлдөөн бол баялгийн үнэ цэн, шударга байдлыг хангахад шийдвэрлэх үүрэгтэй механизм мөн.

- 4) Төсөв, санхүүгийн нөхцөлүүд нь өөрчлөгдөн байгаа нөхцөл байдалд эрүүл саруулаар зохицсон байж, тухайн улс орон ноёд баялгийнхаа үнэ цэнийг бүрэн хүртэх ёстой.
- 5) Баялаг олборлогч үндэсний компаниуд нь өрсөлдөөнт байдлаар арилжааны үйл ажиллагаа явуулах ёстой. Тэд ямар нэг зохицуулалтын чиг үүрэг буюу бусад үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх ёстой.
- 6) Нөөц баялаг ашиглах төслүүд нь байгаль орчны болон нийгмийн ноцтой үр дагавартай байж болно гэдгийг анхаарч, төслийн бүхий л үе шатанд уг үр дагаврыг зөвлөрүүлж байх ёстой.
- 7) Нөөц баялгийн орлого нь дотоодын хөрөнгө оруулалтыг өндөр түвшинд хүргэж, тогтвортой хадгалах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хөхиүлэн дэмжихэд голлон ашиглагдах ёстой.
- 8) Нөөц баялгийн орлогыг үр дүнтэй ашиглахын тулд дотоодын төсвийн зарлагыг ажмаар нэмэгдүүлэн бэхжүүлж орлогын хэлбэлзэлийг харгалзан зарлагаа жигд тогтвортой байлгах ёстой.
- 9) Төр засаг нь нөөц баялгаа улсын төсвийн зарлагын үр нөлөөтэй байдлыг хангах, төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх боломж болгож ашиглах ёстой.
- 10) Нөөц баялагтай холбогдон гарч байгаа шинэ боломжууд, бүтцийн өөрчлөлтүүдэд нийцсэн хувийн хэвцлийн хөрөнгө оруулалтуудыг төрийн бодлогоор удирдан зохицуулж байх ёстой.
- 11) Олборлогч компаниудын эзэн улс, олон улсын хөрөнгийн төвүүдийн зүгээс олон улсын тэргүүн туршлага нэвтрүүлэхийг компаниудаас шаардаж, мөрдүүлдэг байх ёстой.
- 12) Бүх олборлогч компани гэрээ байгуулах, үйл ажиллагаа явуулах, төлбөр төлөхдөө тэргүүн туршлагыг дагаж мөрдөх ёстой.



Гарал: AFP/Arne Jens Roebel, 2021. Photo: agency

малын бэлчээр хомсдож энэ бүс нутгаас уламжлалт мал аж ахуйг бараг шахан гаргаад байна. Энд өндөр ашиг шимтэй үүлдрийн мал, гахай, тахнаны фермерээс өөр малчин гэхээр хүн үлдсэнгүй.

Тэгээд ч 2016 оны сонгуулийн өмнөхөн орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдийн лоббигоор батлагдсан Бэлчээр хувьчлах тухай хууль хэрэгжиж эхэлснээр Төв Азийн их тал нутагт хэдэн мянган жил оршсон бэлчээрийн мал аж ахуй, үүнийг дагаад дэлхийд цорын ганц гэгддэг нүүдлийн соёл иргэнийл төгсөх замдаа орлоо гэж ажиглагчид нэгэн дуугаар бичиж байна.

Өнгөрсөн зуунд дэлхийн анагаах ухаанд монголизм гэдэг өвчний нэр томьёо байсныг манай улсын шаардлагаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага албан ёсны хэрэглээнээс хассан түүхтэй. Гэтэл саяхан гадаадын нэг судлаач Монгол орны өнөөгийн нөхцөл байдал, ялангуяа түүнд хүргэсэн учир шалтгааныг “монголизм” хэмээн нэрлэсэн нь шуугиан тарьж “голланд өвчин” хэмээх нэр томьёотой “өрсөлдөж” эхэллээ. Монголизм буюу “монгол өвчин” гэдэг нь “аливаа улс орон уул уурхайн асар их орлогоор байгаль, газар нутгаа золиослохыг хэлнэ” хэмээн тэр судлаач тодорхойлжээ. Зарим эх орончид үүнийг эсэргүүцдэг ч энэхүү нэр томьёо улам бүр газар авсаар байна.

6 2021 оны хоёрдугаар сард Монголын “Давос” гэгддэг 12 дахь удаагийн Эдийн засгийн форум “Монголын эдийн засаг: Юу хийх вэ?” сэдвийн дор чуулсан юм. Энэ үеэр Монголын нийгэм, эдийн засгийн байдалд өгсөн үнэмлэгт дүгнэлтүүд ихээхэн зөрж улстөрчид, эдийн засагчид, эрдэмтэн судлаачдын дунд ширүүн маргаан өрнөжээ.

Нүүрсний яамны сайд Балдан:

- Сүүлийн арваад жилд ашигт малтмалын салбар, тэр тусдаа нүүрсний компаниудыг дэндүү их шүүмжилж байна. “Өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалдана” гэж үг бий. Өнгөрсөн XX зуунд Монголыг мал аж ахуй авч явсан бол XXI зуунд нүүрс авч яваа. Арван жилийн өмнө Монголд ядуурлын түвшин 39 хувьтай байсан бол одоо хоёр дахин буурсан нь зарим хүний хараагаад байсан нүүрсний ач шүү.

Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Ли Хуа Пүн:

-Хэрвээ та бүхэн мартаагүй бол 2012 оны сонгуулийн дараа танай шинэ Засгийн газар байгуулагдах үеэр манай Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмжид “Иргэдээ ядуу байна гээд мөнгө тараадаг, тэр хэрээр үнэ өсдөг, үнэ өсөхийн хэрээр улам ядуурдаг “чөтгөрийн цагарин”-аас Монгол Улс

гарах найдлага төрөхгүй байна” гэж дүгнэснээс болж манай төлөөлөгч Монголоос хөөгдөх шахаж байсныг бодвол одоо нөхцөл байдал өөрчлөгджээ. Дэлхийд хамгийн томд тооцогдсоор байгаа Таван толгойн орд газрын хувицааны ихэнхийг эзэмшдэг “Эрдэнэс МГЛ” компанийн хувицааг иргэддээ тараасан нь төдийлөн үр ашгаа өгсөнгүй. Дахиад л цөөн хэдхэн хүний гарт хувицаа нь төвлөрсөн хэдий ч монголчууд “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь” зэрэг нэртэй бэлэн мөнгийг хүлээж суухаа больсон байна. Уул уурхай, түүнийг даган хөгжиж байгаа нэлээд олон салбарын дундаж цалин өндөр хөгжилтэй орнуудын жишигт аажмаар дөхөж байна. Гэхдээ эдийн засаг уул уурхайгаар хязгаарлагдсан хэвээр, төрөлжилт явагдаж чадахгүй хэвээр байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. Ийм учраас Монгол орон тогтвортой хөгжлийн замд хараахан гараагүй гэж Дэлхийн банк үзэж байна”.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Улаанбаатар метрополисын Засаг дарга Дүүрэн:

- Би хэдийгээр АНУ-д өсөж хүмүүжсэн ч эцэг өвгөдийнхөө нутагт эргэн ирж энэ ажлыг аваад удаагүй байна. Өнгөрсөн жилүүдэд Улаанбаатар хот ямар ч төлөвлөлтгүй хөгжсөнөөс асар олон тулгамдсан асуудал шийдэгдээгүй байгаа. Харин Орос-Хятадын байгалийн хийн 3-р хоолойг Монголоор дамжуулж тавихаар гурван улсын гэрээг хоёр жилийн өмнө үзэглэснийг хэрэгжүүлж чадвал манай хот Улаанбаатар нэрээсээ бүрмөсөн салж Азийн цагаан дагина нэрээ эргүүлэн авах боломж бүрэн бий.

Нэрт эдийн засагч Баярсайхан:

- Бид баялгаа зарж, нэг ёсондоо хуруугаа хөдөлгөхгүйгээр шахам орлого олж иргэддээ бэлэн мөнгө тарааж, үнэ төлбөргүй хувицаа эзэмшүүлж ирсэн маань урт хугацаандаа монголчуудын эдийн засгийн идэвхийг сааруулж төрөөс хэт хамааралтай болгож улмаар сайн засаглалыг муутгахад хүрсний нотолгоо нь өнөөдрийн төр засаг юм. Уул уурхайгаас асар их орлого олж, бас хэмжээ хязгааргүй нэмэгдэж байгаа төсвийн тендер, худалдан авалтын ихэнхийг хүртдэг MWX зэрэг компаниуд хэт томорч улмаар улс төрд нөлөөлөн өөрийн хүмүүсийг хүссэн албан тушаалд тавьж чаддаг болсныг та бид харж байна... Уул уурхайн баялгийг их хэмжээгээр зөөхөд чиглэсэн дэд бүтцэд асар их хөрөнгө оруулалт хийснээр зарим газарт хүчин чадлын илүүдэл бий болжээ. Энэ мэт ашигтай, ашиггүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Хөгжлийн банкаар хийлгэснээр

тус банк санхүүгийн хувьд хүндэрч улмаар улсын төсөвт ноцтой дарамт үзүүлж эхэллээ... Эдийн засгийн хувьд дорвитой төрөлжилт явагдахгүй, “Товь” компани гэх мэт уул уурхайгаас бусад дотоодын эдийн засгийн салбарын том үйлдвэрүүд төлбөрийн чадваргүй болж дампуурч байгаа нь хувийн банкуудад нэрмээс болж 2021 оны эхэнд бид үндсэндээ гурав дөрөвхөн банктай үлдлээ. Удахгүй гадаадын томоохон банкууд зах зээлийг бүрэн эзлэхэд бэлэн болжээ.

Эдийн засгийн их сургуулийн захирал Галцэрэн:

- Өнөөдөр зарим сайд “монгол өвчин” гэж байхгүй, дахиад 10 жил уул уурхайг саад тотгоргүй хөгжүүлж чадвал алдсанаа нөхөн, байгаль орчноо бүрэн сэргээх мөнгөтэй болно гэсэн утгатай үг хэллээ. Би та нараас асууя. Одоо Өмнөговь аймагт 1 литр савласан ус 5 долларт хүрчээ.

Монголизм буюу “МОНГОЛ ӨВЧИН” гэдэг нь “аливаа улс орон уул уурхайн асар их орлогоор байгаль, газар нутгаа золиослохыг хэлнэ” ...

Өмнөговьчууд мөнгөтэй учраас авч чаддаг байх. Тэгвэл Монгол даяар нийм болвол яах вэ? Тийм ээ, “монгол өвчин” бол “голланд өвчин”-өөс ялгаатай. Яагаад гэвэл Голландад газрын тос нь далайд байсан болохоор сүйтгэх газар байгаагүй. Гэтэл бид энэ их газар нутгийг сүйрүүлж яаж чадав аа... Юуны төлөө? Улаанбаатарт хэдэн өндөр байшин, Хятадын хил рүү баахан зам барих шив дээ. Уул уурхайн орлогын 60 хувийг буцаагаад уул уурхайн дэд бүтцэд булж байна. Энэ 20 давхар Парламентын ордон, 10 давхар Ерөнхийлөгчийн өргөө, Улаанбаатарын хошоо мэтийг барьж тансаглах ямар хэрэгтэй юм бэ? Харицгаа холбооны салбар бүхэлдээ гадныхны мэдэлд орлоо. Уурхайд ажилладаггүй, мэргэжил боловсролгүй олон залуусыг цаашид хэрхэх вэ? Энэ асуултад хариулж чадах хүн байна уу?

Түүнийг 2016-2019 онд Сангийн сайдаар ажиллаж байгаад Ерөнхий сайдтайгаа үзэл бодол зөрчилдсөнөөс болж огцорсон гэгддэг “Альтернатив эдийн засгийн судалгааны төв”-ийн захирал Энхтайван дэмжсэн бөгөөд “Төр уул уурхайгаас өөр бодлогогүй болсноос байгаль орчин сүйрч байгаа юм. Өнөөдөр ашигт малтмал, гааль, татвар зэрэг

төрийн яам, агентлагуудын толгойд уул уурхайн компаниудад ажиллаж байсан хүмүүс томилогдоод байна. Нөгөө талд нь татвар төлөгчдийн мөнгөөр гадаадад өндөр мэргэжил эзэмшээд хэсэг хугацаанд дээрх яам агентлагт ажиллаж мэдлэг, туршилага хуримтлуулсан төрийн албан хаагчид уул уурхайн компаниуд руу хөшүүрч байна. Монголын төр нийм маягаар “эргэдэг хаалга шиг болжээ” гэж ярьсан байна.

Судлаач Очирмөнх:

- Монголын төр засаг барууны хөрөнгө оруулагчдыг татах гэж хэдэн арван жил үйлээ үзсэн. Эхлээд өрнөдийн хэдэн том компани орж ирэх нь ирсэн. Тэд одоо Монголын түүхий эдийг борлуулахын тулд Бээжинд л гүйлдэж явна. Биднээс асуухаа ч больжээ. Өнгөрсөн зуунд Монголын асуудлыг Москвад шийддэг байсан бол одоо Бээжинд шийддэг байх шиг. Нэг л мэдэхэд барууны нэртэй компаниуд Хятадынх болчихсон байх юм. Хятадууд л хөрөнгө оруулж Монголыг аажмаар эрхшээлдээ оруулж байгааг харахгүй байна уу?

Мөн энэ зууны эхээр Монгол банкны ерөнхийлөгч байсан Очирсүрэн хэлэхдээ “Монголын эдийн засагт америк долларын эзлэдэг байсан орон зайг хятад юань эзэлж чөлөөтэй эргэлддэг болсон нь олон хүнд таалагддаггүй. Өнгөрсөн зууны хувьсгалын том ялалт болсон Хятадын янчааныг шахан зайлуулсан ололтыг устгаж 100 жилийн дараа байдал буцаад эргэлтээ гэж зарим популистууд айлгадаг. Энэ бүхэн эдийн засаг огт ойлгодоггүй хүмүүсийн дэмий яриа юм. Яаж ч үгүйсгээд Хятадын юань дэлхийн валют болсон бодит байдлыг хүлээн зөвшөөрөх цаг болжээ. Яг 10 жилийн өмнөх АНУ-ын доллар шиг” гэжээ.

1 Заяаг гэртээ ирээд хэд хонож байтал Өвөр Монгол – Өмнөговийн эрчим хүчний цогцолборын таван жилийн ойн арга хэмжээнд урьжээ. Баруун Цаангийн уурхайгаас тэргүүний

10 ажилчин баярт оролцохоор болсон юм. Тэд Цогцолборын вагонд сууж Даланзадгадын төмөр замын төв буудалд ирэхэд цогцолборын бусад уурхайгаас гадна Улаанбаатараас ирсэн таван вагон, мөн Өмнөговь, Дорноговь аймгийн Засаг дарга нарын тусгай хоёр вагон гэхчлэн нэмж залгагдсаар бүтэн цуваа бүрдэж урд зүгийг зорин хөдөллөө.

Хятад руу нэвтрэх дөрвөн боомт байдаг ч нүүрс ачсан галт тэрэг 24 цагийн турш тасралтгүй цувдаг тул суудлын галт тэрэг нэвтрэхэд зориулан Ганшуунсхайтын боомтод гаргадаг 15 минутын цонхыг энэ удаа хүндэт зочлод баяр хүргэж тусгай ёслол үйлдэхийн тулд 30 минут болгон сунгажээ.

Хил гараад Сэхэгийн төмөр замын буудал дээр бас нэг ёслолд оролцож дахиад хэсэг саатав. Зороод Монгол руу явах галт тэргээр Өмнөговийн уурхайнууд руу зүглэсэн баахан хятад энд хүлээж зогсоно. Заяа хэдэн жил хятадуудтай цуг ажиллаад хэлийг нь гадарлах болсон тул тэдний чанга чанга яриаг сонсохоос өөр яахав. Нэг хижээл эр Монголд анх арван жилийн өмнө очиж байсан, одоо жилдээ дөрвөөс таван удаа очдог, Өмнөговь, Өвөрмонголын хооронд хил нэвтрэх хөнгөвчилсөн журамтай тул бэрхшээлгүй ч яваандаа бүр суурьших санаатайгаа хэлээд Даланзадгадын байрны үнэ ханшийг хэлэлцэнэ. Өөр нэг залуу хамт ажилладаг монгол эмэгтэйтэйгээ (нэрийг хэлсэн нь ойлгогдсонгүй) суух санаатай, тэр нь одоохондоо зөвшөөрөхгүй байгаа гэнэ. “Нэрийг нь ч зөв хэлж чадахгүй байж” хэмээн Заяа дотроо дургүйцээд холдов.

Хөх хотод хүрч тэнгэр баганадсан өндөр барилгуудын дундуур шургаж явсаар цэцэг бүрхсэн галт тэрэгний төв буудалд ойртохын хэрээр “Өвөр Монгол - Өмнөговийн найрамдал манцрутай” гэж хятад, монголоор бичсэн доозон аажмаар тодорлоо. Яг энэ агшинд Заяа “Манайх бүр их нүүрс гаргаад байвал энэ найрамдал улам л бэхжинэ дээ” гэж бодов.



France: AFP/Arnaud Lecoq/Arnaud Lecoq, 2011.



France: AFP/Arnaud Lecoq/Arnaud Lecoq, 2008.


Бэлчээр хувиулах тухай хууль хэрэгжих эхэлснээр Төв Азийн их тал нутагт хэдэн мянган жил оршсон бэлчээрийн мал аж ахуй, үүнийг дагаад дэлхийд цорын ганц гээддэг нүүдлийн соёл иргэншил мөхөх замдаа оржээ.

Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2016 он	2021 он
Нэг хүнд ногдох ДНБ (оны ам. доллароор)	2,786.13	8,999.61	15,310.17
ДНБ-ий бодит өсөлт	15%	4%	3%
Уул уурхайн төсвийн орлого (сая ам.доллар)	733.82	2,451.81	4,449.56
Инфляци	11%	12%	8%
Ядуурлын түвшин	39%	22.70%	20.30%



Орлогын менежментийн үзүүлэлт		
Үзүүлэлтүүд	2011/2009 он	2021 он
Тогтворжилтын сан (тэрбум)	281	778
Хүний хөгжлийн сан (тэрбум)	0	150
Хөгжлийн банк (тэрбум)	50	1000
Орлогын менежментийн индекс (Revenue Watch Institute, мүү-0; сайн-100)	38.2	58
Хөрфиндал индекс (0-1, 1-экспортын төвлөрөл маш их)	0.489	0.49



Засаглалын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2021 он
Шударга ёсны индекс (Global Integrity, мүү-0; сайн-100)	57	71
Банкнүүднээс зээлжих эрхийн зэрэглэл (S&P, 1-10, 10-эрсдэл их)	9	7
Өрсөлдөх чадварын зэрэглэл (World Economic Forum, нийт 142 улс)	98	76
Нээлттэй төсвийн индекс (Open Budget Partnership, мүү-0; сайн-100)	60	50

- ◁ 2012 оны сонгууль харьцангуй шударга болно. Шинээр байгуулагдсан УИХ:
 - ◁ Уул уурхайн салбарыг гүн боловсруулалтын чиглэлээр цаашид хөгжүүлэх Монгол Улсын стратеги боловсруулаха.
 - ◁ Уул уурхайн салбарын хөгжилд таатай орчныг дэмжих, зохицуулах хуулиуд батална.
 - ◁ Цаашид Монгол Улс уул уурхайн салбарын олон улсын зах зээлд голлон тоглогч болох, эрчим хүч үйлдвэрлэгч болох суурийг тавих тодорхой шийдвэрүүд гаргана.
- ◁ Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын давамгайллыг хязгаарлах, дотоодын ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх гэх мэт Монголын оролцоог нэмэгдүүлэх тодорхой зорилтууд дэвшүүлнэ. Гадаадын компаниудад салбарын үндэсний ажиллах хүчний чадавхийг бий болгох, дээшлүүлэх, нийгмийн хөгжилд хөрөнгө оруулах шаардлага тавина.
- ◁ Хөгжлийн банкинд уул уурхайн орлогын 10-аас доошгүй хувийг төвлөрүүлж, гол төлөв уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хөгжүүлэхэд зориулан оновчтой хөрөнгө оруулалт хийнэ. Эрүүл мэнд, боловсролын салбар дахь засгийн газрын хөрөнгө оруулалт тогтвортой хэвээр байна.
- ◁ Бизнесийн салбарынхан урт хугацаанд олон улсын зах зээлд өрсөлдөхүйц бизнес, салбаруудыг бий болгоход идэвхийлэн ажиллана. Эдийн засаг нь уул уурхайн төрөлжсөн салбараас ихээхэн хамааралтай, харьцангуй тогтвортой, өсөлттэй байх боловч үнийн хэлбэлтээд өртөмтгий байна.
- ◁ Төсвийн тогтвортой байдал анхаарлын төвд байна. Үнийн уналтын үед улсын санхүү, төсвийн тогтвортой байлгахад чиглэгдсэн Тогтворжилтын сан байгуулагдаж, зориулалтаараа ашиглагдана. Бие даасан Төв банк инфляцийн эсрэг тууштай тэмцэнэ.
- ◁ Усны хүрэлцээ, чанар зэрэг байгаль орчны асуудал хурцдана.

хөдөө

Хүүхэд ахуйд нь хаа сайгүй багшран харагддаг байсан мал сүрэг, хэдэн мянгаараа цахилах зээрийн сүргийг Заяа хоёр нүдээ чилтэл харуулдаад олж үзсэнгүй. Олон малтай айл ховорджээ. Мянган малтай айл нүдний гэм болсон тул "таван зуут малчин" гэдэг өргөмжлөл өгдөг болсон гэнэ. Хээр талаар морьтой хүн явах нь цөөрч энд тэндгүй элдэв машин тэрэг хөлхөнө.

ИХ ХУВЬ ЗАЯАТАЙ ОРНЫ ИРГЭН ЗАЯА

Заяа баахан сайд, захирлуудын араас үг хэлэхдээ, Дорнод нутгийн газрын тос улс орныг тэтгэж байгаа нь сайн хэрэг, гэхдээ байгаль орчин, малын бэлчээрт үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах хэрэгтэйг сануулаад авсан түүхтэй.

1

Арваадхан жилийн өмнө Австрали л өнөөдрийн Монгол шиг зөв бодлоготой байсан санагдана. Монголчууд өнгөрсөн хугацаанд уул уурхайгаас олж байгаа их баялагтаа тун хэрсүү бодлого барихыг чармайсны үр дүн гарлаа. Улс төрийн байдал жаахан л эвгүй өөрчлөгдөхөд Латин Америк, Араб, Азербайжаны араас орох гээд мөн ч их зовоосон доо. Хэт ирээдүйг харагчид уурхайгаас эцсийн бүтээгдэхүүн гаргаж дэлхийн уул уурхайн их гүрэн болохыг мөрөөдөж байсан юм. Одоо эргээд харахад харин ч тэгээгүй нь оносон аж. Монголын ноолуур дэлхийд Шотланд ноосны хэмжээнд танигдаж дэлхийн одод “Жинхэнэ Монгол ноолуур” хэмээн шагнуулж, Монгол үхрийн мах Шинэ Зеландын хонин мах, Франц дарстай адилтгагдах болжээ. Монголын санхүүгийн салбар Сингапурын нэгэн адил хамгийн аюулгүй, тааламжтай “санхүүгийн диваажин” гэж үнэлэгдэх болов. Монгол орон хамгийн сонирхолтой адал явдалт аялал жуулчлалын газар нутгийн жагсаалтад ямагт дээгүүр орж, жил ирэх тусам ирэх жуулчдын тоо нэмэгдсээр...

Эдийн засагч, эрхзүйч Заяа бусдын жингээр жирийн амьдарч яваа нэгэн. Их хувь заяатай орны иргэн Заяа бол 3,5 сая хүн амтай, уудам нутагтай, хөгжлөөрөө дэлхийд эхний 25-д яваа энэ улсын өнцөг булан бүрт тохиолдож байдаг энгийн бүсгүй. Арваад жилийн өмнө Улаанбаатарт их сургууль төгсоод “петро” нэртэй баахан компаниуд газар дороос нь тос олборлож, газар дээгүүр нь Хятад, Солонгос руу чиглэсэн авто болоод төмөр замууд тавигдаж, газрыг нь солонгосчууд хагалж эдийн засгийн шинэ төв болж эхэлсэн Дорнодыг зорьсон юм. Эхлээд хуулийн фирмд ажилд орж нутгийн малчид ба компаниудын хоорондох газартай холбоотой элдэв маргааны хэрэг дээр ажиллаж



Хөдөөд айлын өвөлжөө хүртэл цахилгаантай болж, зам харгүй сайжирчээ. Байгальд нөхөн сэргээлт хийснээр XIII зууных шиг л атар онгон болсон байна. Малчид боловсрол сайтай болцгоож, малын эмч, технологич мэргэжилтэй хүмүүс их олширлоо. Хуурай сүү, айраг, экологийн цэвэр борц гээд хийхгүй юм алга.

Тусламж үзүүлж: Р.Зайсан, 1988, Photo.com agency

энэ их тал нутгаас нүүдлийн мал аж аж ахуй "хуулийн дагуу" шахагдахыг нүдээр харж дотроо сэтгэл өвдож явдаг байлаа. Тэг тэгсээр ажлаасаа гарч иргэний нийгэмд дэмжлэг үзүүлдэг шинэ хуулийн дагуу малчдын эрх ашгийг хамгаалж өмгөөлөл явуулдаг байгууллагыг үүсгэв ээ. Эндээс олборлосон түүхий нефтийг Сайншанд дахь нэрэх үйлдвэр лүү төмөр замаар тээвэрлэх нээлтийн ёслолд олон нийтийг төлөөлөн оролцож баахан сайд, захирлуудын араас үг хэлэхдээ, Дорнод нутгийн газрын тос улс орныг тэтгэж байгаа нь сайн хэрэг, гэхдээ байгаль орчин, малын бэлчээрт үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах хэрэгтэйг сануулаад авсан түүхтэй.

Заяа дэлхийн хамгийн сүүлчийн гэгдэх энэ их талыг аажмаар элдэв ногоо, ялангуяа цагаан будааны тариалан болгож, бас Буйр нуурын усыг тийш урсаж байгаад таагүй ханддаг. Яагаад гэвэл голдуу солонгосчууд ажилладаг бөгөөд нутгийн иргэдэд ямар ач тустайг бүү мэд. Байгаль орчинтой холбоотой өөр шалтгаанууд ч бий.

Нэг удаа хурдны замаар Халх гол руу давхцж

явахад машинных нь дугуй хагарч зуны халуунд Мэнэнгийн тал дээр хэсэг саатжээ. Тэгэхэд л ойр хавьд нь бүртгэх ч сүүдэргүй энэ нутагт цагаан будаанаас өөр юу хийж болох тухай нэгэн бодол орж ирсэн аж. Тэр нь чацаргана. Ингээд уул уурхайн нөхөн сэргээлтийн зардлыг заавал тэр уурхайн орчинд гэлтгүй зарцуулах санал дэвшүүлж улмаар төсөл болгосон нь дэмжигдэж Буйрын эргээс эхлэн чацаргана суулгасан түүхтэй. Хэдхэн жилийн дотор нөгөө төгөл ой болон ургаж нөмөр, сүүдэрт нь хүн амьтан зогсоход харагдахааргүй болжээ. Байгаль дэлхий ч өгөөжөө хайрлаж намар болгон үлэмж хэмжээний сайн чанарын жимс хураан авах болсон. Чацарганаас гаргаж авсан бэлдмэлийг эндээс шууд Дархан хот руу зөөж Унгар-Монголын хамтарсан эмийн үйлдвэрт туснадаг. Дэлхийд алдартай болоод байгаа энэ үйлдвэрийн бүтээгдэхүүнийг Япон, Хятадын өндөр настнууд, тамирчид маш ихээр авцгаадаг. Мэнэнгийн талд ургасан чацаргана өөр найрлагатай, хүч тамир суулгахдаа гойд гэдэг нь олон туршилтаар батлагдсаар байгаа юм. Ноднин

Дорнодын чацарганы түүхийг маш сонирхолтой өгүүлсэн "Ногоон энерги" баримтат кино олон улсын кино наадмын шагнал хүртсэн билээ. Тэр кино энд чацаргана тарих хөдөлгөөнийг санаачлагч Заяа Мэнэнгийн талд саатаж байгаагаар эхэлдэг...

2 Заяа эцэг, эхээс гурвуулаа. Том ах Хишиг нь гадаадад менежментийн чиглэлээр төгсөж ирээд "Таван Толгой" дахь нүүрсний аварга уурхайд хүчээ сорихоор шийдэж Өмнөговь аймгийн жижиг дунд үйлдвэрүүдийг зохицуулах албаны менежерээр очжээ. Таван Толгой тойрсон жижиг үйлдвэр гэхээр уул уурхайн мэргэжилгүй иргэд энд тэнд цайны газар, гадаадынханд зориулж сийлбэр, сувенирхэн хийдэг төдий байсныг өөрчлөх том төлөвлөгөөтэй ирсэн нь дэмжигджээ. Хишиг эндхийн хүнд даацны машины болон үйлдвэрийн, цахилгаан станцын компьютер, интернэт зэрэгт хэрэг болдог төрөл бүрийн электрон багаж хэрэгсэл, деталиудыг хийх бичил үйлдвэрлэгчдийг зүйл бүрээр дэмжж

эхлэв. Бас гадаадаас ч тийм бичил үйлдвэрлэгчид орж ирэн энэ зах зээл дээр өрсөлдөх боломжийг олгосон. Тухайлбал, уурхай дахь агаарын бохирдол ба хүнсэнд шингэсэн радицыг хэмждэг үзэгний чингээ авсаархан багажийг "Монгол оюун" хэмээх компанийн таван залуу л хийж эхэлсэн. Тэдний хоёр нь гадных, нэг нь Оросын Буриадаас, нөгөө нь Халимагаас ирсэн юм билээ. Саяхан Хишигийн жижиг, дунд үйлдвэрийн салбарт шинэчлэл хийхэд оруулсан хувь нэмрийг менежментийн холбооноос үнэлж 2020 оны Монголын шилдэг менежерээр тодруулсан юм.

Удалгүй түүн рүү янз бүрийн ажил, албан тушаалд ажиллах саналууд цувлаа. Яаманд ажиллах боломж ч гарч ирэв. Уул уурхайн яаман дээр нэлээд хэдэн хариуцлагатай албан тушаалын орон тоо гарсан байв. Сайдаар нь Жалцав гэгч нөхөр ажиллаж байсан юм. Жалцав сайд нүүрс экспортлох гэрээн дээр хятадуудтай хариуцлагагүй ажиллаж улмаар авлига авсан нь шалгалтаар илэрч УИХ-ын гишүүнээс нь АТГ-ын шаардлагаар түдгэлзүүлсэн юм. Бүр эрүүгийн хэрэг үүсгэж жирийн дэглэмтэй хорих ангид таван жилийн ял авч, улсад учруулсан хохирлыг барагдуулах шүүхийн шийдвэр гарсан. Жалцаваас гадна хэд хэдэн улстөрч, яам агентлагийн удирдах ажилтнууд энэ хэрэгт холбоотой байсан нь саяхан илэрч баахан албан тушаалд сонгон шалгаруулалт зарласан нь энэ. Ажлын дадлага туршилагатай, хийж бүтээсэн юмтай хэн боловч нэрээ дэвшүүлж зохих шалгалтыг өгөөд шударгаар өрсөлдөх боломжтой цаг үе нэгэнт ирсэн байв. Хишигийг уг шалгаруулалтад ордог юм уу гэж байтал аймгийн удирдлага бушуухан дэвшүүлж албаных нь даргаар тавсан тул явахыг төвдөөгүй юм.

Харин Заяагийн дүү Баяраа мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгсөөд Сэлэнгэ-Оюу Толгойн усан хангамжийн компанийн хүн болжээ. Булган аймгийн нутгаар дайран өнгөрөх Сэлэнгэ мөрний хадан хавцалтай хэсэг дээр туркчууд аварга том усан цахилгаан станц барьж, үлэмж том далан босгосныг бид мэднэ. Тэнд хураасан усыг бүдүүн хоолой, хүчтэй шахуурганы тусламжтайгаар урагш нь говь руу мянга гаран километр татаж эцсийн цэг нь Өмнөговь хүрч хүн амын болоод уул уурхайн усны бүх асуудлыг шийдэж байгаа аварга байгууламж юм. Баяраа энэ шахуурганы станцын оператор. Саяхан Заяатай гар компьютероосоо холбогдож ажлын байраа сонирхуулсан. Тал тал тийш мушгирсан хоолойнууд, гэрэл товчлуур аншчсан самбар түүний ажлын байр ажээ.

3 Завиагийнх Чойбалсан хотоос зүүн урагш, Хэрлэн гол руу харсан хоёр давхар байшинд амьдардаг. Байшингийнхаа хоёр хажуугаар дүүрэн жимсний мод тарьсан харагдана. Нөхөр Алтангэрэл нь Дорнод бүсийн салхины эрчим хүчний цогцолборын инженер. Эднийх сургуулийн насны хоёр хүүтэй.

Үдээс хойш том хүү Баяраа хичээлээсээ орж ирэнгүүтэй жижиг цүнхнээсээ хэд нугалсан эхдэг iPhone гаргаж ирээд цэнэглэхээр тогонд залгав. Хүүхэд бүрт тарааж өгсөн уян дэлгэцтэй хавтгай компьютерт их юм багтах тул сурагчийн цүнх ихэд хөнгөрсөн билээ. Хүү хэсэг цайлж сууснаа iPhone-оо дэлгэлээ. Өнөөдрийн хичээл дээр нь “Миний өвөө” сэдвээр зохион бичлэг хийх даалгавар өгсөн тул Архангайд суугаа өвөө рүүтэй интернэтийн дуудлага хийв. Өчигдөр аймгийн төвийн эмнэлэгт үзүүлж сумынхаа төв дээр ирээд гэртээ амарч байхтай нь таарсан тул хэрэг зоригоо хэлж баахан яриулж бичлэг хийж авлаа. Дараа нь монгол хэлний яриаг текст болгодог шинэ программаар буулгаж ашиглах санаа төржээ. Одоогийн хүүхдүүд гараар юм бичихгүй, залуу болж гэж томчууд үглэдэг нь атаархсан хэрэг ч байж магадгүй.

“... Өвөө нь намар Улаанбаатарт хагалгаанд ороод ирснээс хойш бие их сайн байгаа. Өчигдөр аймагт очиж үзүүлэхэд сайн эдгэж байна гэсэн. Хавдар гээч өвчин шүү дээ. Уул нь ноднинхон шинжилгээнд ороход зүв зүгээр байсан даа. Та нар ч гэсэн жил болгон үзүүлж харуулж байгаарай. “Нэгдсэн зургаа”-д очоод хагалууллаа. Хариад уу гээд тан өгсөн. Нэг орос хүүхэн гадаадаас ирчихсэн миний өмнө орсон доо, хөөрхий. Хамаг мөнгөө бариад л ирсэн янзтай. Яагаад наашаа ирэв гэж оросоор хальт мулт асуухчаа аядлаа. Танайх уламжлалт эмчилгээгээ орчин үетэй нь хавсарч хүний бие сэтгэлийг хамтад эмчилдэг гэж интернэтээс олж уншсан гэж байна шүү. Тэр эрүүлийг хамгаалах салбарт багагүй мөнгө хаясан, эхлээд эмч нар нь гологдоод их л хэцүү байсан гэсэн одоо нэг тэгширч байгаа юм уу даа янз нь. Тэр жил олон хүнийг гадаадад дадлагажуулж, мөн гаднаас олон сайн эмч авчирч эмч нараа бэлдсэн нь сайн хэрэг болжээ. Эмч нар ч их баяжиж байгаа юм байх. За тэр яахав...”

Улаанбаатарт нэг үеэ бодвол түгжрэл утаагүй сайхан болсон байна билээ. Гэхдээ л тэр их шуугиан настай хүнд хэцүү байсан. Бас юмны үнэ ч лут

өндөр харгдсан. Машинтай явахар төлбөргүй зогсоол гэж алга, явганаар болохоор метроных нь учрыг олохгүй тоороод л. Нутагтаа ирсэн чинь яасан ч сайхан юм. Манай хөдөө чинь нэг үеэ бодоход айлын өвөлжөө хүртэл цахилгаантай болж, зам харгүй сайжирчихлаа. Чулуутын голын эргэн тойрон дахь байгальд нөхөн сэргээлт хийгээд XIII зууных шиг атар онгон болгосон байна. Орчин үеийн мал нядалгаа, цагаан идээ боловсруулах үйлдвэртэй боллоо. Малчид боловсрол сайтай болгоож, малын эмч, технологич мэргэжилтэй хүмүүс их олширлоо. Хуурай сүү, айраг, экологийн цэвэр борц гээд хийхгүй юм алга.

Өвөө нь удам дамжсан өвөлжөө, хаваржаагаа хувьчилж авсан болохоор тэндээ гадаадын жуулчин авдаг жижиг тур бааз нээдэг юм уу. Яг эртний хэв маягаар тохижуулж эмээл хазаар, гүүний зэл бэлдэнээ, танагтай байгаа дээрээ. Ийм үзвэр дэлхий даяар моодонд ороод байхад өвгөн би зүгээр суугаад яахав. Одоо ч жуулчид дотоод гадаадын галтгүй нүүдлийн соёлыг үзэх гэж төдийгүй дотор нь орж амьдарч үзэх гэх ирдэг болж дээ. Үнээ саах, ааруул идээ хийх, малд явах гээд бүх юмыг л сонирхдог бололтой. Ойр хавьд машин унаа багшраад байхгүй, ногоон үйлдвэр завод, зөнхон

Манай сүүлийн арван жилийн түүх бол үндсэндээ бид засаглалаа хэрхэн сайжруулсан тухай юм. Энэ бол бид улс орныхоо хөгжлийн талаар хэрхэн санаа сэтгэл нэгдсэн, Монголын төр хэрхэн орчин үеийн болж өөрчлөгдсөн тухай түүх юм.

уламжлалт мал аж ахуйгаас өөр зүйл байхгүй болохоор гадаад төдийгүй бидэнд бас сайхан санагдах юм байна шүү. Тэгж байгаад бизнес маань сайн болбол “орж ирсэн” он залуу гайгүй нисдэг тэрэг нутгийнхантайгаа нийлж байгаад олоод авах бодолтой яваа. Тэгвэл дуртай үедээ хот орж хэдэн хүүхдээ эргээд байна. Саяхнаас Дарханц онгоцны бензин үйлдвэрлээд эхэллээ. Гайгүй хямдхан юм билээ.

Манай нутгийн урдхан байсан алт, зэсний гадаадын том уурхай хаагдсан харагдана билээ. Их л том хот барих нь гээд шуугианд байсан. Юмаа ухаад дуусангуутаа буцаагаад булччихсан юм

гэхчин. Хамаг байшин саваа гэр ачаалж байгаа юм шиг л аваад явчихсан. Тортой хашаан дотор хэдэн цагаан зээр бэлчээд хоцорсон байх юм. Хойд Сэлэнгээс нааш татсан газар доогуурх хоолойгоор урсгадаг ус нь харин хэвээрээ үлдэж. Их цэвэрхэн ус байдаг. Манайхан ноднингийн гангаар Өгий нуур ширгэсэн байсныг гурван өдөр крантыг нь нээгээд дүүргэчихнэ билээ. Аль хаврын үерээр орж ирсэн усыг хадгалж байгаад оруулж ирлээ гэж байгалийн яамны сайд зурагтаар хэлж байнээ. Сайд хүүг оросууд үер уснаас буриадуудыг хамгаалсан гээд одонгоор шагнав уу даа. Нөгөө Гэрлээ хүүгийнх тэнд тариа тарьж байгаа. Усны гачаангүй, малын хал гэхгүй их аятайхан нутаг олоод ферм нээсэн. Улаанбаатар - Баян-Өлгийн төмөр замаас холгүй, ердөө хажууд нь. 2121-р тоочиг гэхээр хүмүүс андахгүй. Би хааяа очиж малын тэжээл, гурил, жимс авдаг юм. Өвөө нь усан үзмэнд нутасгүйг ч юу эс андахав. Үндэсний үйлдвэрийнхээ алм, хар чавгыг хүртэл тэднийхээс авч байна...”

4 Заяа оройн хоолоо хийхээр завдаж байтал бага хүү Цэнгэл дэгдэн гүйж ирээд “Ээж ээ, би танд туслах уу, юу хийхэв?” гэнгээ зурагтаа асаатал сүүлийн хэдэн долоо хоногийн турш бестселлерийн жагсаалтын тавдугаарт яваа эдийн засагч Д.Гантөгсийн “Монголын их үсрэлт” номын англи орчуулгын нээлтийг үзүүлж байгаатай таарав. Цэнгэл хүү нийгмийн ухаан сонирхдог ахыгаа дуудав. Энэ арга хэмжээний хамгийн хүндэт зочноор анхны Ерөнхийлөгч П.Очирбат уригдаж хэзээний алина хөгжилтэй зангаараа ярьж харагдана. “Та нар намайг яагаад урьсныг мэдэж байна. Тийм ээ, би 1991 онд Монгол Улсыг “Азийн бар” болно гэж хэлээд гучаад жил балбуулсан хүн дээ. Нэг хэсэг баар улс болгосон хэрэгт орох шахсан. Тансаг найр гэж хэлснийхээ төлөө Тансагмаагийн Очирбат ч болж үзлээ. Нэг зураач намайг гучин жил бар болгон зурж байгаа. Би нэг их фотогеничний хүн биш болохоор тэр биз. Зарим хүмүүс “Хэзээ бар болох гэнээ?” гэж ирээд ам асуудаг байсан... Өнгөрсөн 20 жилд би “бар” гэдэг үгийг олны өмнө дахиж хэлээгүй ч сэтгэлийнхээ мухарт итгэж явсан шүү. Өвөө цагт хэдийгээр “бар” гэдэг үг моодноос гарсан ч 30 жилийн өмнөхөөр бол Монгол маань Азийн бар улс боллоо шүү дээ”.

Төгсгөлд сэтгүүлч залуу номын зохиогч Гантөгсөөс яагаад номоо англи хэлнээ хөрвүүлэх болсон талаар сонирхсонд тэрээр “Манай сүүлийн



Орлогын Ажиглагч Хүрээлэн нь нефть, байгалийн хий, ашигт малтмалын ноёд баялгийг олон нийтийн сайн сайхны төлөө үр ашигтай, нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлаар ашиглахыг дэмждэг ашгийн бус, бодлого, судалгааны байгууллага билээ. Чадавхи бэхжүүлэх, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа, судалгаа, нөлөөллийн ажлаар дамжуулан улс орнуудад байгалийн баялгийнхаа үр ашгийг хөгжлийн зорилгоор ашиглахад нь тусалдаг.

Энэхүү хүрээлэн нь байгалийн баялаг ихтэй улс орнуудад тулгардаг асуудлуудыг шийдэхийн төлөө ажилладаг, энэ чиглэлийн цорын ганц байгууллага юм. Ийм улс орнуудад ядуурал, аклигал, зэвсэгт мөргөлдөөн зэрэг олон асуудал бий болсон байдаг билээ.

Товч түүх

Орлогын Ажиглагч Байгууллага нь 2002 онд Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн нэгэн хөтөлбөр болж эхэлсэн бөгөөд Азербайжан, Казахстан, Ирак улсад илүү анхаарал хандуулж ялангуяа нефтийг олсон орлогыг эрх баригчид хэрхэн цуглуулж, ашиглаж байгааг анхааран ажилладаг байсан. Энэ хөтөлбөрийг үүсгэн байгуулагчид болох Нээлттэй Нийгэм Сан, Уильям болон Флора Хьюлетт Сан, Норвегийн Нефтийн хөгжлийн сан зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа нь улам бүр эрэлт хэрэгцээтэй болж байгааг олж харсны үндсэн дээр 2006 онд Орлогын Ажиглагч Хүрээлэн бие даасан байгууллага болсон билээ.

Орлогын Ажиглагч Хүрээлэн нь Нью-Йорк хотод төвтэй, Лондон болон Гана улсын Аккра хотод салбар оффисуудтай бөгөөд Азербайжан, Нигери, Индонези, Танзани болон Перу улсуудад бүс нутгийн төлөөлөгчийн газруудтай. Нийт 30 гаруй улсад ажилладаг.

Хийж буй ажлууд

Орлогын Ажиглагч Хүрээлэн нь байгалийн баялгийн засаглал, зарцуулалтыг сайжруулах цогц аргачлал ашиглан ажилладаг бөгөөд энэ арга нь холбогдогч бүх талыг татан оролцуулдаг билээ. Улс орнуудад нефть, байгалийн хий, ашигт малтмалын ашиглалтын үе шат бүр буюу хайгуул хийх шийдвэрээс, олборлолт хийх, орлогын менежмент, эдийн засгийн хөгжлийн төлөө орлогыг зарцуулах бодлого хүртэл бүхний л үе шатыг нягтлан судалж үзэхэд нь тусалдаг.

арван жилийн түүх бол үндсэндээ бид засаглалаа хэрхэн сайжруулсан тухай юм. Энэ бол бид улс орныхоо хөгжлийн талаар хэрхэн санаа сэтгэл нэгдсэн, Монголын төр хэрхэн орчин үеийн болж өөрчлөгдсөн тухай түүх юм. Байгалийн баялаг ихтэй бусад улс орон сургамж авахад хэрэг болох юм болов уу гэж бодсон хэрэг” хэмээн хариуллаа.

Заяа “Нээрэн тийм шүү. 2012 оны сонгуулийн дараа улс орон даяар хэлэлцүүлэг болж уул уурхайгаас олох мөнгөө юунд зарцуулах вэ гэж хөдөө хотгүй яригдсан. Хөгшин залуугүй бүгд л уул уурхайгаас хэт хамааралтай болохын уршиг, иргэдээ бэлэн мөнгөнөөс хараат амьдралтай болгохын хор хөнөөлийг ойлгох болж, “Толланд өвчин”, “Персийн булангийн синдром” зэрэг нэр томъёог андахгүй сайн мэддэг болсон доо” гэж бодов. Түүний бодлыг таасан юм шиг том хүү нь “Ээж ээ, манай улс ядуу орон байсан гэсэн яаж одоогийнх шиг болсон бэ?” гэнэ.

Заяа “Энэ тухай ч их урт яриа болно доо. Харин түүх нь богино хугацааных юм. Ээж нь товчхон хэлж өгөхийг хичээе. Баяраа миний хүү ээждээ улаан лооль амтлах сүмс бэлдээд өг дөө. Чацарганы тос, оливын тос хоёр халбага хийгээд дээр нь жаахан гич нэмээд сайн хутгаарай. Ямааны сайхан шинэ бяслаг авсан, улаан лоольтой хольж амттай зууш хийнэ” гээд цааш өгүүлэв. “Ер нь бол уул уурхайгаас эхтэй юмаа, миний хүү. Биднийг залуу байхад манай оронд уул уурхайн тэсрэлт болж энд тэндгүй нүүрс, зэс, алтны орд шил шилээ даран нээгдсэн юм. Түүгээр ч зогсохгүй дэлхийд ховор уран, газрын ховор элемент гээд эрдэнэсийн үүд хаалга онгойж байлаа. Асар их баялгаа хүн ам цөөн

манай орон дангаараа олборлож барахгүй байсан тул гадаадын том компаниудтай хамтран ашиглах гэрээ хэлцэл хийгдсэн. Эхэндээ бид их барьц алдсан. Энэ их баялгаа ашиглах мэдлэг туршлага ч байсангүй. Дээрээс нь өвсгөө самбаатай улсууд амин хувийн эрх ашгаа их амжуулцагдсан. Эдийн засаг өсөөд байсан хэргээ хүн ард нь ядуу хэвээрээ л байв. Баялгаа худалдаж, ухаж богино хугацаанд их мөнгө олсон хүмүүс төр засагт их нөлөөтэй



болсон юм. Сонин хэвлэлээр л дүүрэн аалига хээл хахуулийн тухай бичдэг байсан ч хэн ч харуцлага хүлээдэггүй байлаа.

Олон түмэн шударга ёсыг маш ихээр хүсэмжлэх болсон тул 2012 оны Улсын Их Хурлын сонгуулиар шударга ёс тогтоохын төлөө зүтгэж ирсэн хүмүүсийг голлож сонгосон юм. Төрд хэн орж ирснээс үл хамааран нийтийн баялгаас үл хулгайлах тийм орчин нохцөлийг тэр хүмүүс бүрдүүлж эхэлсэн. Энэ нь ч үр дүнгээ өгч шинэ ажлын байр шил шилээ харан бий болж, амьдрах тавтай тухтай орчин өдөр ирэх бүр бүрэлдэж байв. Бизнес зөвхөн төрийнх байхаа болнод дээрээс нь хөрөнгө оруулалтын төслүүдийг ул суурьтай бодож боловсруулж, шударгаар шалгаруулаад ирэхээр заавал төрд шургалж байж бизнес хийх шаардлагагүй, харин ч сонирхлын зөрчил энээ тэрээ гээд тендер авахад түвэгтэй болоод эхэлсэн. Ер нь хүү минь аалига гэдэг юмны чинь гол аюул нь олны хийх бүтээх итгэл, сэтгэлийг алдагдуулдаг юм шүү дээ. Бизнесийн арга ухаан, мэдлэг чадвар, хичээл зүтгэлээрээ уралдахын оронд төрд орох, ойртох арга сүвэгчлэх, хээл хахуулиараа уралдахаар улс орны хөгжлийн үндэс тасарч байгаа нь тэр дээ” гэж хэлээд ширээгээ засаж дуусав. Гал тогооны өрөөнд орж ирээд зогсож байсан аавыгаа хүүхдүүд сая л анзаарч “Өө аав ажлаасаа ирчихэж” хэмээн хоор болцгоов.

Хоол идэх зуур хоёр хүү нь аав ээж хоёроо ээлжлэн баахан асуулгаар булж гарав. “Аав аа, манай улс уурхайгаас их мөнгө олсон уу, төрийгээ юунд зарсан бэ?” гэнэ. “Эхэндээ ч тийм сайнгүй л байсан. Харин 2012 оны сонгуулийн дараа Оюу Толгой, Таван Толгой төслийн түншүүдтэйгээ гэрээг өөрчлөх тухайд харилцан нааштай тохиролцоонд хүрч цааннд байгуулагдах гэрээний нөхцөлүүдийг сайжруулахад зөвлөх дотоодын болон олон улсын мэргэжилтнүүдээс бүрдсэн багийг байгуулж ажиллуулсан нь их үр дүнтэй болсон. Үүний үр дүнд чамлахааргүй мөнгө олох болсон. Тэр үед хэчинэн мөнгө олж байгааг мэдэх гэж зөндөө л юм болдог байсан. Одоо ч амар болж,

ОРЛОГЫН АЖИГ ЛАГЧ ХҮРЭЭЛЭН



Орлогын Ажиглагч Хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагаа бол иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх явдал юм. Орлогын Ажиглагч Хүрээлэн нь нефть, байгалийн хий, уул уурхайн салбар бүрт үйл ажиллагаа явуулдаг 50 гаруй түнш байгууллагуудаа санхүүгийн болон мэргэжлийн сургалт явуулж, дэмжлэг үзүүлдэг. Орлого Ажиглагч Хүрээлэн нь орон нутгийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран бий болгосон бүс нутгийн мэдлэгийн төвүүд нь илүү өндөр түвшний дэмжлэгийг үзүүлдэг. Олон улсын “Төлснөө Мэдээл” Санаачилгыг үүсгэн байгуулагч бөгөөд Африк, Ази, Евро-Ази, Латин Африк болон Хойд Америкийн улсуудын “Төлснөө Мэдээл” иргэний нийгмийн байгууллагуудын эвслийг дэмжин ажилладаг.

Орлого Ажиглагч Хүрээлэн нь нөлөөллийн кампанит ажлаараа дамжуулан уул уурхайн салбарын ил тод, харуцлагатай байдлын дэлхийн стандартыг бий болгох олон улсын кампанит ажлыг тэргүүлэн ажиллаж байна. Түүнчлэн Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилгыг анх үүссэн цагаас нь хойш улам бүр хөгжүүлж,

хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж ирсэн билээ.

Орлогын Ажиглагч Хүрээлэн нь засгийн газруудад уул уурхай, нефтийн хуулиудыг боловсруулж, орлогын менежментийг сайжруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлдэг. Төв засгийн газар байгалийн баялгийн орлогыг хуваалцдаг улс орнуудад орон нутгийн болон бүс нутгийн удирдлагатай хамтарсан төслүүдийг хэрэгжүүлдэг.

Орлогын менежментийн шилдэг тэргүүний туршлагын талаар судалгааны материал, тайланг цуглуулсан номын сан, мэдээллийн баазыг бүрдүүлж байгаа бөгөөд үүнд гэрээ байгуулах, нефтийн сангийн хуулиуд, уул уурхайн санхүүгийн зохицуулалт, парламентын зохицуулалт зэрэг хүрээ хамрагдан орсон байдаг. Дэлхийн нефть, алт, зэс, алмаазын хамгийн том олборлогч 40 гаруй улсуудын ил тод байдлын талаар судалгаа харьцуулалт хийдэг Орлогын ажиглагчийн индексийг боловсруулж гаргаж байна. Мөн тус хүрээлэн нь засаглалын тогтолцоог сайжруулахад хувь нэмэр оруулахад нь тус болох өгөгдөл, мэдээллийн шинжилгээ хийх, хуваалцах боломжийг хэрэглэгчдэд олгох дижитал арга хэрэгслийг боловсруулж байна.

Орлогын Ажиглагч Хүрээлэн бодлого боловсруулагчид, аж ахуйн нэгж компаниуд, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд харилцан яриаг бий болгох болон засаглал, харуцлагатай байдлыг сайжруулахад олон талын хамтын ажиллагааг бий болгохыг эрмэлздэг билээ.



Гарал зурвиг Д.Жаргалсайхан, 1996.

өдөр бүр л цаг агаарын мэдээ шиг мэдээлж байна. Энэ жилийн олсон орлого өнөөдөр гэхэд 6,5 тэрбум долларт хүрээд байна гэсэн.

“Тэгээд мөнгөө юунд зарсан бэ? Дахиад л уурхай нээгээд байсан уу, аав аа?” гэж Баяраа шахамдуулав. “Бэлэн мөнгө замбараагүй тараахаа болиод уул уурхайн ашгийг тусгай санд төвлөрүүлсэн юм билээ. Иргэд ба төрийн харилцаа татвар дээр тогтдог юм. Иргэд, бизнесийнхний төлсөн татвар уул уурхайн тэр их орлого хоёрыг нэг тогоонд хийчихвэл иргэд төрөө хянаж байхад хэцүү болох тул байгалийн баялгийн орлогыг тусад нь салгасан. Тэгж байж төрөө тунгалаг цомхон, иргэдийнхээ төлөө болгож чадсан юм. Харин уул уурхайгаас орж ирдэг төрийн болон хувийн хэвшлийн тэр их нацдаар тоологдох орлогыг ирээдүйн эрсдэлийн санд, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц зэрэг чухал шаардлагатай салбарт олон

нийтийн саналыг харгалзан зарцуулах жишиг тогтчихлоо. Мэдээж уул уурхайн бүтээгдэхүүнээ гүн боловсруулахад бас хэрэглэнэ шүү дээ. Зэсийн баяжмалаа боловсруулж цэвэр зэс гаргаж авдаг болсон нь их сайн хэрэг болсон. Зэсийг хот чимэглэл, орон байраа гоёх, ахуйн хэрэглээний сав суулга хийхэд ч бас их хэрэглэж байна. Хүний биед хортой элдэв янзын хуванцар сав суулгыг хүний эрүүл мэндэд тустай зэс сав суулгаар нь сольсонд ээж чинь маш их баяртай байгааг та хоёр мэднэ шүү дээ”.

Зава нохрийнхоо яриаг үргэлжлүүлэн “Манай Монгол шиг эмзэг байгаль орчинтой улс уурхай нээгдэсний зоргоор ашиглаад байж болохгүй тул төр стратегийн гэгдэх томоохон ордуудаа ээлж дараатай ашиглахаар шийдсэн. Тэр нь ч оносон. Амьдрах өөр боломж мундахгүй байхад заавал энэ сайхан орноо сүйтгэж, байгаль орчноо

доройтуулаад яахав дээ. Бид ямар 100 сая ард түмнийг тэжээх гэж байгаа бий. Ердөө гурав дөрөвхөн сая хүнд хийх сонирхолтой сайхан ажил зөндөө л байна” гэлээ.

5 Цагаан сарын битүүний энэ өдөр 2021 оны Анагаах ухааны салбарын Нобелийн шагналыг Японы хоёр эрдэмтэнтэй хамт авсан Дэмбэрэлийн Батсайхан эх орондоо түр ирж монголчууд анхны Нобелийн шагналт эх орон нэгтгээ угтаж авч баяр хоор болцгоов. Монгол мэргэжилтнүүд олон улсад өндөр үнэтэгдэж, тив дэлхийн өнцөг булан бүрт чухал ажил алба хаших болсны нэг жишээ энэ билээ. Арваад жилийн өмнөөс хамгийн их эрдэм номтой хүүхдүүдээ шалгаруулж олон улсын аль том сургуулиудад олноор нь суралцуулах болсны үр

дүн гарч байгаа нь энэ гэх. Үүний ачаар дотоодын их, дээд сургуулиуд ч сайн багшаар хангагдаж, өрсөлдөх чадвар нь сайжирч байна. Ингэж Монгол нутагт зөвхөн Оюу Толгой орд үр өгөөжөө хайрлаад зогсохгүй, мөн Монгол хүний оюун ухаан, эрдэм билиг цар хүрээгээ тэлж байгаа нь үнэхээр бахархуунтай. Одоо монголчууд алзахгүй.

Өнөөдөр 2022 оны хоёрдугаар сарын 22-ны өдөр. Маргааш төмөр бар жилийн шинийн нэгэн болно. Азид төдийгүй дэлхийд эдийн засгийн өсөлтөөрөө дээгүүрт орох болсон манай улсын үндэсний баярын өдөр. Энэ өдөр бүгд монгол дээлээ өмсөж мянга мянган жилийн турш тэмдэглэсээр ирэхдээ өчүүхэн ч өөрчлөгдөөгүй их ёс заншил цагаан сарын золголт өргөн дэлгэр болох учиртай. Харин цагаан сараас бусад нь ихэд хувирч, тэгэхдээ сайн тал руугаа өөрчлөгджээ. Монгол түмний Зава өнө мөнхөд дээшээ байг!

Гарал зурвиг С.Лосов, 1913.



Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2016 он	2021 он
Нэг хүнд ногдох ДНБ (оны ам. доллараар)	2,786.13	8,720.50	17,999.10
ДНБ-ий бодит өсөлт	15%	6%	7%
Уул уурхайн төсвийн орлого (сая ам.доллар)	733.82	2,563.25	4,203.2
Инфляци	11%	8%	5%
Ядуурлын түвшин	39%	20.40%	10.70%



Орлогын менежментийн үзүүлэлт		
Үзүүлэлтүүд	2011/2009 он	2021 он
Тогтворжилтын сан (тэрбум)	281	1600
Хүний хөгжлийн сан (тэрбум)	0	1500
Хөгжлийн банк (тэрбум)	50	3000
Орлогын менежментийн индекс (Revenue Watch Institute, муу-0; сайн-100)	38.2	78
Херфиндал индекс (0-1, 1-экспортын төвлөрөл маш их)	0.489	0.3



Засаглалын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2011 он	2021 он
Шударга ёсны индекс (Global Integrity, муу-0; сайн-100)	57	81
Банкнүүдэн зээлжих эрхийн зэрэглэл (S&P, 1-10, 10-эрсдэл их)	9	5
Өрсөлдөх чадварын зэрэглэл (World Economic Forum, нийт 142 улс)	96	65
Нээлттэй төсвийн индекс (Open Budget Partnership, муу-0; сайн-100)	60	80

- 2012 оны сонгууль харьцангуй шударга явагдана. УИХ иргэдийн итгэл, дэмжлэгийг хүлээж, тэнд суудалтай намууд хамтарч ажиллана.
- УИХ-аас баталсан улс орны хөгжлийн урт хугацааны бодлого, хөтөлбөрүүдийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг эрэмбэлж, хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, өргөн олон нийтээр хэлэлцүүлэн иргэдээ цогц мэдээлээр хангана.
- Орлого, зарлага, хөрөнгө оруулалтын холбоотой хөгжлийн бүхий л асуудлаар төрийн ил тод, хариуцлагатай байдал төв, орон нутгийн түвшинд үйл ажиллагааны хэм хэмжээ болсон байна.
- Төрийн гаргаж буй бодлого шийдвэр нь Монгол Улсыг эдийн засаг, улс төрийн хувьд бие даасан байдлаа бүрэн хэрэгжүүлж байгааг илтгэнэ.
- Эдийн засгийн төрөлжилтийг хангах зорилгод нийцүүлэн Хөгжлийн банкинд үлэмж хөрөнгө оруулалт хийгдэнэ.
- Төв банкны хараат бус байдал бэхжиж, Төсвийн хариуцлагатай байдлын тухай хууль хэлбэрэлтгүй хэрэгжиж, Тогтворжилтын сан төсвийн хэлбэлзлийг зохицуулаад зогсохгүй, гадаадад хөрөнгө оруулалт хийхэд ашиглагдаж эхэлнэ.
- Боловсрол, хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, биотехнологийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдэнэ.
- УИХ, Засгийн газар алсыг харсан ухаалаг, ирээдүйд учирч болох эрсдэлийг бүрэн дүүрэн тооцсон хариуцлагатай шийдвэр гаргаж хэвшсэн байна.



www.forum.mn